МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,150.408... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.06.29. Пүрэв. №125 (4739) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

**УЛС ТӨР**

ЗАРИМ АЙМГИЙН НААДАМ ТЭМДЭГЛЭХ ХУГАЦААГ ӨӨРЧИЛЛӨӨ

**II нүүрт**

**МЭРГЭЖИЛТНИЙ ҮГ**

М.ОТГОНЧИМЭГ: НЭГ Ч ИРГЭНИЙГ ОРХИГДУУЛАХГҮЙ БАЙХ ЗАРЧМААР ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЖ БАЙНА

**VI-VII нүүрт**

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**



Өдөр +32

Шөнө +19

ХЭН НЬ ХЭН БЭ



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

# Муулуулах тусам өнгө ордог Н.НОМТОЙБАЯР

Х.НОРЖИН

*"Хэн нь хэн бэ" булангийнхаа өмнөх дугаарuудаар УИХ-ын гишүүдийн хэн нь хэн бэ, өмнө нь хэн байв, одоо хэн болов, юу хийж байна, сонгогчдын итгэл найдварыг дааж чадах төрийн түшээ мөн үү гэдгийг тольдон уншигчиддаа мэдээлж байгаа билээ. Өмнөх дугаартаа УИХ-ын сонгуулийн 1-14 дүгээр тойргийн гишүүдийг онцолж, нэр дэвшигчийн намтар, хувь хүнийхээ хувьд хэн болох, цаашлаад төр түших ажлаа хэрхэн нэр хүндтэй хийж буйг нь уншигчиддаа хүргэсэн. Тэгвэл энэ удаа УИХ-ын сонгуулийн 15 дугаар тойрог болох Дорнод аймгаас УИХ-ын гишүүнээр томилогдсон УИХ, Засгийн газрын гишүүн Н.Номтойбаярыг онцолж байна. Харин дараагийн дугаарт, мөн энэ тойргоос УИХ-д сууж буй төрийн түшээ болох УИХ-ын гишүүн Ц.Болорчулуун таныг онцлох болно.*

**Дэлгэрэнгүйг V нүүрнээс**

# ГАДААДАД АМЬДАРЧ БАЙГАА ИРГЭДИЙН САНАЛЫГ ЭХНИЙХЭЭР НЬ ТООЦЪЁ

Н.ПУНЦАГ

МонголУлсынтавдахьЕрөнхийлөгчийг сонгох сонгууль энэ сарын 26-нд боллоо. Парламентад суудалтай гурван нам төлөөллөө илгээж, Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдүүллээ. Харамсалтай нь гурван нэр дэвшигчийн хэн нь ч нийт санал өгсөн сонгогчдын олонхийн дэмжлэгийг хүлээсэнгүй. Уг нь АН-аас нэр дэвшиж байгаа Х.Баттулга олонхийн санал авсан л даа. Гэхдээ нийт сонгууль өгсөн хүний 50 хувь дээр нэмэх нь нэг санал авах ёстой гэсэн асуудал босч ирчихээд байна. Гэтэл Үндсэн хууль болоод Сонгуулийн хуулиндаа тийм нарийн заалт байхгүй байгаад байдаг. За энэ ч яахав, ямар ч байсан дахин санал хураалт болох нь тодорхой болчихлоо. АН-аас нэр дэвшигч Х.Баттулга, МАН-аас өрсөлдөж буй М.Энхболд нарын хооронд өрсөлдөөн өрнөх нь. Дахин санал хураалтыг СЕХ долдугаар сарын 9-нд хийхээр товлоод байсан. Харин АН-ын шаардлагын дагуу, хуулиа баримталж, ажлын өдөр буюу долдугаар сарын 7-нд хийхээр болж товоо өөрчиллөө, өчигдөр. Ямар ч байсан баяр наадам арай эхлээгүй байхад, тэгээд ажлын өдөр сонгуулийн дахин санал хураалт болох нь. СЕХ хуулиа баримталж байна гэсэн үг. Одоо харин монголчууд дахин сонгуулиа идэвхтэй өгч, хэн нэгнийг нь Ерөнхийлөгчөөр сонгох хэрэгтэй байна. Хэрвээ ахиж ирц хүрэхгүй, эсвэл аль нэг нэр дэвшигч нь 50-иас дээш хувийн санал авахгүй бол гурав дахь шатны сонгууль болох аюултай. Дахиад л төсвийн өч төчнөөн мөнгө урсана. Нөгөө талаар энд нэг асуудлыг бодолцож үзэх хэрэгтэй байна. Улс төрийн намууд ч гэсэн СЕХ-нд санал хүргүүлээч ээ. Гадаадад амьдарч байгаа иргэдийг дахин сонгууль өгүүлж, бөөн ядаргаа болж байхаар эхнийхээр нь тооцчихвол яасан юм. СЕХ гадаадад амьдарч байгаа иргэдийн дахин санал хураалтыг долдугаар сарын 4-ний өдөр хийхээр товлоод байсан. Тэгвэл өчигдөр шийдвэр гаргаж, долдугаар сарын 4, 5-ны өдөр дахин санал хураалтыг явуулахаар шийдвэрлэсэн байна билээ.

**Үргэлжлэл нь III нүүрт**

Дугаарын 60 мөр

# Сошиал сонгуульд хэрэггүй юм байна

Г.ГАНЧИМЭГ

Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтын дүн эцэслэн гарах хараахан болоогүй ч урьдчилсан дүнгээр АН-аас нэр дэвшигч Х.Баттулга нөгөө хоёр нэр дэвшигчээсээ хол тасархай түрүүлсэн. Харин хоёр, гуравдугаар байр будлиантай боллоо гэдэг дүнг ард түмэн тавьж байна. Эрхэм сонгогчдын нүдний өмнө л зүв зүгээр байсан сүлжээ гэнэт гацаж, гуравдугаарт байсан нэр дэвшигчийн саналын тоо тав таван мянгаар өссөөр өглөө болоход өмнөх нэр дэвшигчээ гүйцэж түрүүлэв. Өөрөөр хэлбэл, МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар саналаа луйвардуулж хохирчээ. Үүнийг МАХН-ын гишүүд, дэмжигчид эсэргүүцэж буйгаа албан ёсоор мэдэгдэж, хэвлэлийн хурал хийсэн. Тиймээс МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатарыг хоёрдугаарт гарч ирсэн нэр дэвшигч гэж үзье. Харин их ч бай, бага ч бай саналыг илбийн аргаар "хулгайлаад" ч гарч ирээгүй МАН-аас нэр дэвшигч М.Энхболд яагаад энэ удаагийн сонгуульд "баян ходоод" болчихов.

Ер нь энэ удаагийн сонгуульд урлаг, соёлын гоё хүүхнүүд, хөөрхөн хөөрхөн юм яриад байсан залуучуудаас илүү зарим нэг улстөрийн намын захиалгаар уу, эсвэл зарим нэг төрийн байгууллагын өөрсдийнх нь санаачилгаар уу гэдгийг мэдэхгүй ч олны өмнө үзүүлсэн илбийн үзүүрбэрүүд л хамгийн гайхамшигтай нь байж чадлаа. Тиймээс МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатарыг хоёрдугаарт гарч ирсэн нэр дэвшигч гэж үзье. Харин их ч бай, бага ч бай саналыг илбийн аргаар "хулгайлаад" ч гарч ирээгүй МАН-аас нэр дэвшигч М.Энхболд яагаад энэ удаагийн сонгуульд "баян ходоод" болчихов. Хамгийн эхний үзүүлбэр нь МАН-аас нэр дэвшигч М.Энхболдын "Эвтэй Монгол, ээлтэй төр" гэсэн бичиг бүхий сурталчилгааны самбар ганцхан хоногийн дотор бүгдээрээ "Эвтэй Монгол ялна" гэж өөрчлөгдсөн нь зарим сонгогчийн эгдүүцлийг хүргэсэн бололтой. "Тэртэй тэргүй олны танил хүн ахин дахин зурагт самбар хэвлүүлж мөнгө үрж яадаг байна аа", "Хэлсэн үг нь хэд хэдэн янз болж хувирдаг ийм хүнд би л лав саналаа өгөхгүй" гэх мэтийн сэтгэгдэлтэйгээр фэйсбүүкт зураг хөрөгтэйгөө дурайж л байсан.

**Үргэлжлэл нь III нүүрт**




ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# Дахин санал хураалтыг долдугаар сарын 7-нд товлолоо

Б.ДАВААХҮҮ

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хоёр дахь бүрэн эрхийн хугацаа дуусч буйтай холбоотойгоор дараагийн Ерөнхийлөгчийг тодруулах бүх нийтийн сонгууль энэ сарын 26-нд болсон. Сонгуульд эрх баригч МАН-аас УИХ-ын дарга М.Энхболд, сөрөг хүчин АН-аас гишүүн асан Х.Баттулга, МАХН-аас УИХ-ын гишүүн асан С.Ганбаатар нар нэр дэвшин өрсөлдсөн. Гэвч, нэр дэвшигчдийн хэн нь ч сонгогчдын талаас илүү хувийн санал авч чадаагүй учраас манай улсад түүхэндээ анх удаагаа шийдвэрлэх шатны санал хураалт явуулахаар болсон билээ. Хоёр дахь санал хураалтад МАН болон АН-ы нэр дэвшигч өрсөлдөх юм. СЕХ-ноос өмнө нь шийдвэрлэх шатны санал хураалтыг долдугаар сарын 9-нд товлосон ч, улс төрийн нам, холбоо, эвсэлүүд эсэргүүцэн хугацааг урагшлуулахыг шаардсан байдаг. Тэгвэл тус шаардлагыг СЕХ хэлэлцээд ирэх сарын 7-нд явуулахаар болсон байна. Энэ талаар СЕХ хэвлэлийн хурал зарлан олон нийтэд мэдээллээ.

**Үргэлжлэл нь II нүүрт**

ДЭЛХИЙ



# Хойд Солонгос Д.Трампыг Гитлер хэмээв

Баллистик пуужин, цөмийн зэвсгийн хөгжүүлэлттэй холбоотойгоор Хойд Солонгос АНУ-тай хурцадмал харилцаатай байгаа. Тэгвэл Пхеньян энэ сарын 27-нд АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампыг нацист Германы дарангуйлагч Адольф Гитлертэй зүйрлэжээ. Д.Трамп өнөөдөр БНСУ-ын шинэ Ерөнхийлөгч Мүн Жэ Интэй анхны хоёр талт уулзалтыг хийхээр төлөвлөсөн. Хоёр улсын төрийн тэргүүний ярилцах гол сэдэв нь Хойд Солонгосын эсрэг авах арга хэмжээ юм.

Хойд Солонгосын төрийн өмчит KCNA агентлаг Д.Трампын улс төрийн бодлогыг "21 дүгээр зууны Нацизм" хэмээн хурцаар шүүмжилсэн мэдээллийг цацаж, эсэргүүцэл илэрхийлсэн байна. Ерөнхийлөгч Д.Трамп сонгуульд ялалт байгуулан тангаргаа өргөх үедээ "Аугаа Америкийг дахин бүтээнэ" гэх үгийг хэлж байсан удаатай. Тэгвэл энэ талаар KCNA "Америкчууд хамгийн чухал гэсэн үзэл суртал нь хүч түрэмгийлэн дэлхийд ноёрхолоо тогтоох гэсэн эрмэлзлэл бөгөөд Гитлерийн бодлоготой ижил" гэдгийг онцолжээ.

Түүнчлэн, Трамп дарангуйлалаа зөвтгөхийн тулд бусад улс орныг дайсан болон холбоотон гэсэн хэсэгт хувааж, "Гитлерын дарангуйллын бодлогыг даган дуурайж байна" гэсэн аж.

| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2345.00 | 2359.00 | ФУНТ | 2968.00 | 3059.00 |
| ЕВРО | 2639.00 | 2690.00 | РУБЛЬ | 38.70 | 40.60 |
| ИЕН | 20.85 | 21.15 | ЮАНЬ | 342.50 | 347.00 |

| Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2345.00 | 2359.00 | ФУНТ | 2974.00 | 3047.00 |
| ЕВРО | 2632.00 | 2697.00 | РУБЛЬ | 38.54 | 41.32 |
| ИЕН | 20.68 | 21.23 | ЮАНЬ | 343.00 | 347.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# Дахин санал хураалтыг долдугаар сарын 7-нд товлолоо



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Хоёр дахь шатны санал хураалттай холбоотойгоор УИХ-ын гишүүн О.Баасанхүү санал хураалтыг долдугаар сарын 4-нд, АН, Ардчилсан залуучуудын холбоо товыг урагшуулж, долдугаар сарын 6-ны өдөр явуулахыг шаардсан байдаг. Тэгвэл тэдгээр шаардлагыг СЕХ хэлэлцэн судлан үзсэний үндсэн дээр урагшлуулж, долдугаар сарын 7-нд явуулахаар товложээ.

Учир нь саналын хуудас хэвлэх, хөдөө орон нутагт хүргэх, тоног төхөөрөмжөө бэлтгэхэд хугацаа шаардлагатай учраас хамгийн боломжит хувилбараар хугацааг товлосон гэдгээ СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн онцолсон юм.

Түүнчлэн, гадаад улс оронд ажиллаж амьдарч буй монголчуудад саналын хуудсыг оногдсон хугацаанд хүргэхэд нислэгийн хуваарьтай холбоотойгоор бэрхшээл гарч буй учир санал хураалтыг долдугаар сарын 4-5-нд явуулахаар болсон байна.

*Хэвлэлийн бага хурлын үеэр сэтгүүлчдийн асуултад хариулт өгснийг дор хүргэе.*

**-Гадаадад байгаа иргэд бүртгүүлж байж саналаа өгсөн. Өмнөх бүртгэлээрээ саналаа өгөх үү?**

-Зургадугаар сарын 26-ны өдрийн сонгуулийн үргэлжлэл учраас сонгогчдын нэрсийн бааз өөрчлөгдөхгүй. Өмнө нь санал өгөхөөр бүртгэгдсэн 7209 хүн байгаа. Энэ нь үндсэндээ нэг аймаг гэсэн үг. Тийм учраас өөрчлөгдөхгүй. Бүртгэгдсэн сонгогчдын нэрсийн жагсаалтын дагуу саналаа өгнө. Өөрчлөгдөх хоёр зүйл бий. Зургадугаар сарын 15-наас улсын хэмжээнд шилжилт хөдөлгөөн зогссон байгаа. Тэр өдрөөс долдугаар сарын 7-ныг хүртэлх хугацаанд нас барсан иргэдийг бүртгэлээс хасна. Мөн энэ хугацаанд насанд хүрсэн цөөн хэдэн иргэний нэрсийг сонгогчдын жагсаалтад нэмж оруулна. Тэгэхээр энэ хугацаанд насанд хүрсэн иргэд харьяа дүүрэг, хороондоо очиж саналаа өгөх боломжтой. Дашрамд дуулгахад, Монгол Улсын Засгийн газар хуралдаж, хоёр дахь санал хураалтад зарцуулагдах 7.2 тэрбум төгрөгийг нөөц хөрөнгөнөөс шийдвэрлэхээр болсон байгаа.

**-Хөдөө орон нутаг руу шилжиж болох уу?**

-Иргэдийн шилжилт хөдөлгөөнийг зогсоосон. Иргэний шилжилт, сонгогчдын шилжилт хөдөлгөөн гэж хоёр бий. Сонгогчийн шилжилт хөдөлгөөн нь баазаасаа өөрчлөгдөхгүй. Өмнө нь сонгуулиа хаана өгсөн, тэндээ л саналаа өгнө. Улс орон даяар 27-ны өдрөөс эхлэн долдугаар сарын 9-ний өдөр хүртэл шилжилт хөдөлгөөнийг зогсоосон байгаа.

**-Дахин санал хураалтын ирцийг нийт сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын 50 хувиар тооцох уу. Тухайн өдөр санал өгсөн иргэдийн 50 хувиар тооцох уу?**

-Сонгогчийн ирцтэй холбоотой өөр өөр ойлголт байгаад байна. Санал хураалтын нийт ирц 50-иас дээш хувь байх босготой. Нэр дэвшигчдийн тухайд 50-иэс дээш хувийн буюу 50 хувь нэмэх нь нэг хүний санал авсан нь шууд сонгогдох ёстой. Гэтэл энэ сарын 26-ны сонгуульд хамгийн их санал авсан нэр дэвшигч Х.Баттулга 38 хувийн санал авсан байгаа. Иймээс хоёр дахь удаагийн санал хураалтыг явуулахаар болсон. Хоёр дахь шатны санал хураалт мөн ирцийн босготой. Нэр дэвшигч хэдэн хувийн санал авсан бэ гэдгээс илүүтэй ирц 50 хувьд хүрсэн эсэхийг эхлээд харах ёстой. Санал хураалтын ирц 50 хувьд хүрээгүй тохиолдолд долоо хоногийн дотор нэмэлт санал хураалт явуулна. Өөрөөр хэлбэл, саналаа өгөөгүй иргэдийн дунд нэмэлт санал хураалт явуулна гэсэн үг. Ингээд дүнг нь өмнөх саналд нэмж, гаргана. Тэгэхээр ирц 50 хувьд хүрэх ёстой. Дээр нь тухайн өдөр саналаа өгсөн сонгогчдын 50-иас дээш хувийнх нь саналыг авсан нэр дэвшигч сонгогдоно гэж ойлгох хэрэгтэй.

**-МАХН-аас Баян-Өлгий аймгийн саналын хуудсыг 100 хувь гараар тоолъё гэсэн шаардлагыг хүргүүлсэн гэсэн. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ?**

-Баян-Өлгий аймгийн саналыг тоолох асуудал дээр СЕХ хэлэлцэж, тооллого явуулах эсэхийг шийдвэрлэнэ. Дашрамд хэлэхэд, Сонгуулийн хуулийг хэлэлцэж байх үед СЕХ-ноос хяналтын тооллогыг 100 хувь хийе гэсэн саналыг оруулж байсан. Тэгэхэд эрхэм гишүүд дэмжээгүй. Харин одоо сонин зүйл ярьж байна. Ийм байж болохгүй.

**-Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуулийн ирцийг сайжруулах чиглэлээр дорвитой алхмууд хийдэг. СЕХ-ноос энэ чиглэлээр ямар нэгэн арга хэмжээ авч ажиллах уу?**

-Сонгогчид хандсан урамшуулал, торгуулийн арга хэмжээ авахыг Монгол Улсын хуулиар зөвшөөрдөггүй. Гадаадын улс оронд бол зөвшөөрдөг. Тийм учраас уламжлалт аргаараа хэвлэлийнхэнтэйгээ хамтраад сонгогчдоо уриалсан мэдээллийг л бид түгээнэ.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## МАН Баян-Өлгий аймгийн саналын хуудсыг гараар тоолохыг шаардав

Б.БОЛОРТУНГАЛАГ

Монгол Ардын намаас Тусгаар тогтнолын ордонд өчигдөр хэвлэлийн бага хурал зарлаж, Баян-Өлгий аймгийн сонгогчдын саналын хуудсыг гараар тоолох шаардлагыг СЕХ-нд хүргүүлж буйгаа мэдэгдлээ. МАН-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Г.Ганбаяр "С.Ганбаатар Баян-Өлгий аймгийн санал хураалтын дүнд МАН-ыг нөлөөлсөн мэтээр ярьж байгаа юм. Тус аймгийн саналыг гараар тоолох шаардлагыг СЕХ-нд хүргүүлж байна. Бид өмнө нь гараар тоолох шаардлага хүргүүлж байсан. Гэтэл зөвхөн 50 хувийг нь гараар тоолохоор болсон. Баян-Өлгий аймгийн саналыг гараар тоолоход намуудын төлөөллийг мөн байлцуулах хэрэгтэй. МАХН-аас нэр дэвшигч зөвхөн Баян-Өлгий аймгийн асуудлыг онцолсон учраас тухайн аймгийн саналтай холбоотой шаардлагыг хүргүүлж байна. Говь-Алтай зэрэг аймагтай холбоотой асуудал байхгүй. МАН-ыг санал хураалтад нөлөөлсөн гэсэн хардлагыг арилгах нь зүйтэй гэж үзсэн. СЕХ гараар тоолсон санал хураалтын мэдээллээ олон нийтэд мэдээлэх ёстой" гэв. Манай улсын анхны Ерөнхийлөгчийн сонгууль 1993 онд болж байсан бөгөөд түүнээс хойш анх удаагаа шийдвэрлэх шатны санал хураалт явуулахаар тов гарсан билээ. Гэвч, МАХН-ын зүгээс энэ удаагийн сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдээд байгаа юм.

## Түр завсарласан чуулган хуралдана

Ерөнхийлөгчийн ээлжит сонгуультай холбогдуулан УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаан түр завсарласан билээ. Тэгвэл энэ сарын 30-наас эхлэн УИХ-ын чуулган хуралдахаар болжээ. Өнөөдөр байнгын хороод хуралдах юм. Байнгын хорооны хуралдаанаар Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл, УИХ-ын гишүүн Н.Учрал, Ж.Энхбаяр нарын энэ сарын 15-нд өргөн мэдүүлсэн Багшийн хөгжлийн тухай хуулийн төслийн өргөн мэдүүлсэн, төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх, Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслийн талаар авч хэлэлцэнэ.

ЗАСГИЙН ГАЗАР

## Зарим аймгийн наадам тэмдэглэх хугацааг өөрчиллөө

Засгийн газрын хуралдаан өчигдөр боллоо. Хуралдаанаар зарим аймгийн наадам тэмдэглэх хугацааг өөрчлөх тухай асуудлыг хэлэлцжээ. Тухайлбал, Баянхонгор сум байгуулагдсаны 60 жилийн ойг Улсын баяр наадамтай хамтатган долдугаар сарын 21-22-нд тэмдэглэхээр шийдвэрлэсэн байна. Мөн зарим суманд шүлхий өвчин гарсан, нийт нутгаар нь гантай байгааг харгалзан Дорноговь аймгийн наадмыг долдугаар сарын 28-29-нд, Зүүн бүсийн хурдан морины уралдаантай хамтатган Сүхбаатар аймгийн наадмыг долоодугаар сарын 28-29-нд зохион байгуулахаар боллоо. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн хоёр дахь санал хураалт болох 2017 оны долоодугаар сарын 7-ны өдөр орон нутагтаа аймаг, сумын наадам хийхгүй байхыг аймгуудын Засаг дарга нарт үүрэг болгожээ. Мөн хуралдаанаар 128 мянган иргэнийг тогтвортой ажлын байртай болгох асуудлыг хэлэлцсэн байна. Дэлхийн банкны 25 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд зарцуулахаар болжээ.

Үр дүнд нь ажил хайгч иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 15-34 насны залуучууд ажилтай болж, сургалтад хамрагдан, зээлд хамрагдах боломж бүрдэх гэнэ. Тодруулбал, дөрвөн жилийн хугацаанд 128 800 иргэнийг тогтвортой ажлын байранд зуучлах бөгөөд тус бүр 10 мянган хүнийг сургалт, зээлд хамруулж санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөсөн байна. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт залуучуудаа сургаж дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадаас авдаг ажилчдын тоог 50-иас дээш хувиар бууруулахаар тусгажээ.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

PHOTO NEWS




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

*Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль энэ сарын26-нд орон даяар болсон ч нэр дэвшигчдийн хэн нь ч 50 хувиас илүү санал аваагүй учраас хоёр дахь шатны санал хураалтыг зохион байгуулахаар СЕХ-ноос шийдвэрлэсэн билээ. Тэгвэл сонгуулийн дүнг луйвардсан гэх намууд ч байгаа юм. МАХН-аас энэ удаагийн сонгуулийг будлиантай болсон учраас дүнг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдээд байгаа юм. Тэгвэл Монголын Ардчилсан Холбооноос Сонгуулийн Ерөнхий хороонд дахин санал хураалтын товыг наашлуулах шаардлага хүргүүлэв. Тус холбооны гишүүд СЕХ-ны байрны гадаа талбайд өчигдөр жагсаал зохион байгууллаа. Тэд сонгуулийг хуулийн дагуу шударга явуулах, хуулиа биелүүлэх, эрх баригчдаас хараат бус ажиллах, ард түмний эрх ашигт үйлчлэхийг шаардаж жагссан юм.*

ҮЗЭЛ БОДОЛ

# Гадаадад амьдарч байгаа иргэдийн саналыг ЭХНИЙХЭЭР НЬ ТООЦЪЁ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Учир нь дэлхийн өнцөг булан бүрт саналын хуудас хүргэхээс авахуулаад олон ажил байгаа. Нэг өдөр иргэд саналаа өгөхөд хүрэлцэхгүй гэж үзээд хоёр өдөрт санал авахаар шийдвэрлэж байгаа юм байна. За тэр хэдэн өдөр саналаа өгөх нь хамаа алга. Саяа сонгууль болоход гадаадад байгаа иргэдээс 7209 хүн бүртгүүлсэн байсан. Сонгуулиа өгөхөөр шүү дээ. Түүнээс 4714 хүн саналаа өгсөн байна билээ. 50 гаруй хувь нь яаж ийж байгаа сонгуулиа өгч, иргэний үүргээ биелүүлжээ. Гэхдээ тэд Монголд байгаа шиг амьдарч буй гэрийнхээ хажууханд саналаа өгчихгүй. Тус улсад байгаа Элчин сайдын яам болоод төлөөлөгчийн газарт очиж саналаа өгнө. Гадаадад ажиллаж, амьдарч байгаа болгон тэр улсынхаа нийслэлд байна гэж байхгүй. Өөр олон хотуудад нь ажиллаж, амьдарч, суралцаж байгаа. Гэтэл тэр хотод нь төлөөлөгчийн газар энэ тэр байхгүй бол нийслэл рүү нь явах болно биз дээ. Солонгост амьдарч байгаа хэсэг залуус бүр автобус хөлслөөд, олон км зам туулж байж очиж саналаа өгсөн юм билээ. Мэдээж гадны оронд ажиллаж байгаа болохоор чөлөө олдоно гэж юу байх вэ дээ, хөөрхийс. Тийм болохоор бөөнөөрөө тохироод, нэг өдрийн ажлаа хаяад санал өгсөн гэдгээ цахим ертөнцөд бичиж л байна. Ар гэрийнхэндээ хэлж байна. Австралид гэхэд залуучууд онгоцоор нисч очиж байж саналаа өгсөн байна билээ. Монгол Улсын төрийн тэргүүнийг сонгох сонгуульд ингэтлээ ач холбогдол өгч байна шүү дээ. Гэтэл одоо дахин санал хураалт явуулна гээд сууж байна, бид. Харин эхний удаад идэвх гаргасан залуучууд дахин санал хураалтад оролцож чадахгүй гэдгээ илэрхийлж эхэлж. Аргагүй шүү дээ, хэн тэгээд л дахиж онгоцоор нисч очоод саналаа өгөх вэ дээ. Хэн тэгж ажлаа тасалж, автобус хөлсөлж саналаа өгдөг юм. Хэцүү биз дээ. Хүний нутагт, хэцүүхэн байгаа нь ойлгомжтой. Харин ч тэд сонгуульд нэлээд идэвхтэй оролцлоо. Тэр хөдөлмөрийг нь үнэлээд, дахин санал хураалтыг гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн дунд явуулахгүй баймаар байна. Ердөө л эхний өгсөн саналаар нь тооцоод явчихад болно шүү дээ. Ядаж ирцэнд ч гэсэн тустай. Ингээд бичихээр Х.Баттулга олон санал авсан болохоор түүнийг дэмжиж байна гэж бодох байх. Тиймээ, хэдэн санал илүү өгсөн нь үнэн. Гэхдээ М.Энхболд нэр дэвшигчид саналаа өгсөн 1000 хүнийг ч хүндэтгэж үзэх хэрэгтэй шүү. Хэнд саналаа өгсөн бэ гэдэг нь хамаагүй. Дахиж санал өгөхөд л хэцүү. Энэ зарчмын асуудлыг СЕХ эргэж нэг хараач ээ. Журам гаргаад л шийдчихэж болох байлгүй дээ. Хэрвээ дахин санал хураалтад гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийг заавал оролцуулах хэрэгтэй юм бол өмнө нь саналаа өгөөгүй иргэдээ л уриалчихъя. Эхний сонгуульд саналаа өгөхөөр бүртгүүлсэн 7200 хүнээс үүргээ биелүүлээгүй үлдсэнийг нь дахин санал хураалтад хамруулчихгүй юу. Тэгэхэд л асуудал шийдэгдэнэ биз дээ. Ер нь тэгээд ч дахин санал хураалтыг гадаадад явуулахгүй, эхний өгснөөр нь тооцчихвол Монгол Улсын Засгийн газар овоо хэдэн төгрөг хэмнээд л авна. Манайд л ашигтай. Энэ хувилбарыг улс төрийн намууд, цаашлаад СЕХ-ны удирдлагууд бодолцоно биз ээ.

Дугаарын 60 мөр

## Сошиал сонгуульд хэрэггүй юм байна

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Мөн МАН-ын өөрсдийнх нь сошиал орчинд тараасан “2000-аас дээш лайктай хүнтэй хамтарч ажиллана” гэдэг ажлын зар бий. Эндээс харахад, МАН-ынхан сошиал сурталчилгаанд ихээхэн анхаарал хандуулж, сонгуулийн үеэр гарч ирсэн золбин сайтуудыг багагүй хөрөнгө мөнгөөрөө санхүүжүүлсэн бололтой. Харин үр дүн нь жаахан тиймэрхүү л байна даа, пиарчдаа. Хамгийн элдэвтэй нь өөрөө мөнгө төлөөд хэт өндрөөс унах тэр мэдрэмж ямар хэцүү байгаа бол. Унаган зан нь угаасаа аядуу зөөлөн хүн юм болохоор нэг их уурлаж ч чадахгүй чавга шиг жаахан улайгаад л өнгөрч байгаа байх даа, хөөрхий минь. Гэхдээ л харамсалтай. Дээр үед сониноор сайд, ялаа хоёрыг алдаг байсан бол орчин цагт сошиалаар сонгуульд нэр дэвшигч, улстөрчдийг эрхэмлэн дээдэлдэг нэр төр, эхнэр хүүхэдтэй нь хамт ангуучилж, эргэж босохгүй болтол нь шороотой хутгадаг болжээ.

Үүн дээр нэмээд хэлэхэд “Дээр үед л дээ...” гэж байгаад сонин дээр бас баатар болж мандаж байснаа дурсдаг хүмүүс ч бий. Өөрөөр хэлбэл, буруудн нүд хурц, зөвд чих зөөлөн юм байна, цаасан хэвлэл. Тэгээд бас ч гэж мэргэжлийн дипломтой нөхдүүд бор боргоо дуудуулан байж ажилладаг юм, энэ өдөр тутмын сонинуудад чинь. Мэргэжилдээ хайртай, үнэлж хүндэлдэг учраас нэг их аашаа эвдэж чадахгүй ээ, тэд чинь. Бас редакцийн бодлого, ёс зүй ч гэж байна. Тиймээс л сошиалаар яваад байсан шиг аймшгийн хар пи арыг та өдөр тутмын аль ч сониноос үзэхгүй л дээ. Харин сошиалын пиарчид бол аймшгийн кинонд дуртай хэсэг үзэгчдийнхээ сэтгэл зүй дээр тоглолт хийж чадаж байна. Гэхдээ гаргасан алдаа нь тэднийг олон нийтийн буюу бүх ард түмний төлөөлөл гэж андуурсан явдал юм. Хариуд нь аймшгийн киног таашаал авахын тулд л үздэг гэдгээ бодит амьдрал дээр баталлаа, ард түмэн чинь. Тэгээд ч фэйсбүүк, твиттерийг 40, 50-хан мянган хүн л хэрэглэдэг юм билээ шүү дээ. Амташсан хэрээ 13 дахина гэгчээр сонгуулиар хуурамч нэрээр нээсэн хаягаа зарж гаршсан хүмүүс хэдэн хаягтай ч байж мэднэ. Ингэхээр чинь энэ тоо арай багасна аа даа. Тэгээд намуудтай гэрээ хийхдээ өөрийнхөө нээсэн 3-4 сайт, 10 пэйж хуудсуудыг хамтарч ажилладаг гэж танилцуулдаг юм уу хаашаа юм. Ганц, хоёрхон хүн руу л сурталчилгааны төлбөр гэж хамаг мөнгө нь урсаад байдаг бололтой. Харин ард түмэн, эрхэм сонгогчид одоо үүнд хууртахааргүй цензуртай болсон байна, Браво. Чангаас чанга алга ташъя.

Өмнөх буюу УИХ-ын сонгуулиар АН ч сошиалаар сурталчилгаагаа хийлгэнэ гээд энэ алдааг гаргаж байсан. Харин түүн дээр нь бодит анализ, зөв дүгнэлт хийж чадсангүй МАН-ынхан нэмэгдлээ. Нэг намынхаа онгирч гүйж байгаад унасан замаар нөгөө нам нь хар хурдаараа гүйгээд орчихсоноос ялгаа юун. Тэгээд ч сонгогчид тэнэг биш. МАН-ынхан пиарчидаа шинэчлэх хэрэгтэй юм байна. Өнөөдрийн өрнөсөн үйл явдал гол дүр нь өөрчлөгдсөн болохоос биш яг 2009 онд болоод өнгөрсөн нэг явдлыг ард түмэнд санагдуулж байна. “Сонгогчид тэнэг бишийг үргэлж сана” гэдэг сануулга ач холбогдол өгч, хөрөнгө мөнгөө цацаад байсан фэйсбүүк, сошиал орчинд чинь хаяглагдаж хэдийнэ хүрсэн байна лээ. За тэгээд хошин шогийнхон ч сонгуулийг хүртэл хошин шог болгож чадах юм байна гэдэг егөөг 2020, 2021 он хүртэл битгий мартаарай, эрхэмсэг ноёд, хатагтай нар аа.

Сошиалын улстөрийг доторлох нь байтугай гадарладаггүй бяцхан хийрхэгчдээс болгоомжлох ёстой гэдэг том сургамжийг хоёр том сонгууль дамнуулан хүртлээ. Одоо хангалттай биш үү. Эцэст нь үнэн гэдэг эвлүүлэгтэй, эвлүүлэггүй постоос ч илүү хүчтэй. Түүн дээр нэмэх хамгийн өндөр оноо нь ард түмэнтэйгээ ойрхон амьдарч, эгэл байх юм байна. Тэгээд дээрээс нь амлалтаа бүү март. Татвар нэмэхгүй, шатахууны үнэ болоод их, дээд сургуулийн төлбөр өсөхгүй, хүүхдийн мөнгийг алгачлалгүй олгоно гэх мэт гоё амлалтуудыг ард түмэн хэзээ ч мартахгүй. Харин хэзээ биелэхийг нь нүдээ ширгэтэл хүлээж байгаа. Ядрах тумсаа байж болох боломж бүрийг хайж, амьдралаа босгож ирэхийн төлөө тэмцэх болно, монголчууд.


# МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ 2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД БАКАЛАВРЫН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРТ ЭЛСЭЛТ АВНА

*Үндэсний батлан хамгаалахын их сургууль нь 1921 онд үүсэн байгуулагдсан боловсролын ууган байгууллага бөгөөд эдүгээ боловсролын бүх түвшний зэрэг эзэмшүүлэх сургалт явуулдаг, Зэвсэгт хүчин, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, иргэний нийгэмд өндөр боловсрол, мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэдэг, 2 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн шилдэг менежменттэй сургалт, судалгааны байгууллага юм.*

## БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

Элсэхээр бүртгүүлэгч нь өөрийн хүсэл сонирхол, итгэл үнэмшлээрээ сонголтоо хийсэн, бие бялдрын болон гадаад хэлний шаардлагыг хангасан, ёс суртахууны зөв хүмүүжил, төлөвшилтэй, суурь өвчингүй, нийгмийн хэв журам, хууль, дүрмийг хүндэтгэн сахиж биелүүлдэг, бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой Монгол Улсын иргэн байна.

Орон нутгаас суралцагч элсүүлэх хуваарьт зөвхөн тухайн аймагт оршин суугаа иргэд, Улаанбаатар хотоос элсүүлэх хуваарьт нийслэл болон заасан аймгуудад оршин суудаг элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн иргэд бүртгүүлнэ.

Улаанбаатар хот болон Дархан-уул, Орхон, Төв, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Сэлэнгэ аймаг, Багануур дүүргийн элсэгчдийг цахим хэлбэрээр элсүүлнэ.

Бусад аймгуудад элсэгчдийг бүртгэх үйл ажиллагааг Монголын их, дээд сургуулиудын консорциумаас орон нутагт томилогдсон элсэлтийн комисс зохион байгуулна.

Бүртгүүлэгч нь сонгосон бүлэг хөтөлбөрт хамаарах элсэлтийн шалгалтын хичээлээр 2016 болон 2017 онд ЭЕШ өгсөн батламжтай байна. Бүртгүүлэгч нь зөвхөн хүчин төгөлдөр нэг батламжаар бүртгүүлэх эрх эдэлнэ.

Цахим бүртгэлд амжилттай бүртгэгдсэн, элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоороо тухайн сонгосон бүлэг хөтөлбөрийн шаардлагыг хангасан элсэгч сургалтын төлбөрийн 30 хувийг төлж суралцах шийдвэрээ баталгаажуулна.

Бүртгүүлэгч нь ҮБХИС-д бүртгүүлэхээс өмнө элсэлтийн ерөнхий шалгалтын шалгуулагчийн буланд нэвтэрч, өөрийн хувийн мэдээлэл болон дүнтэй танилцаж, зөрчилтэй асуудал байвал урьдчилан шийдвэрлүүлсэн байна.

Мэргэжлийн боловсролын болон хөгжмийн урлаг хөтөлбөрт бүртгүүлэгч нь ур чадварын шалгалт өгнө.

Математик, физик суурьтай хөтөлбөрт элсэхийг хүсэгч нь гадаад хэлний шалгалт өгсөн байвал тухайн хөтөлбөрт элсэх давуу тал болно.

Бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүдэд элсэгч нь дараах босго оноог хангасан байна.

| Бүлэг | Хөтөлбөр | Босго оноо | Элсэлтийн шалгалт I-70% | Элсэлтийн шалгалт II-30% |
|---|---|---|---|---|
| I | Математик суурьтай хөтөлбөр - I | 580 | Математик | Нийгмийн тухай мэдлэг |
| II | Математик суурьтай хөтөлбөр - II | 580 | Математик | Физик |
| III | Физик суурьтай хөтөлбөр | 580 | Физик | Математик |
| IV | Гадаад хэл суурьтай хөтөлбөр | 600 | Гадаад хэл /англи,орос хэл/ | Нийгмийн тухай мэдлэг |
| V | Нийгмийн тухай мэдлэг суурьтай хөтөлбөр | 620 | Нийгмийн тухай мэдлэг | Математик |
| VI | Хими суурьтай хөтөлбөр | 560 | Хими | Математик |
| VII | Монгол хэл суурьтай хөтөлбөр /Хөгжмийн урлаг/ | 560 | Монгол хэл | Нийгмийн тухай мэдлэг |
| VIII | Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөр | 480 | Математик | Физик |

Хэмжээст оноо нь 700-аас дээш оноотой элсэгчдийг /эрэгтэй/ сонсогчоор элсүүлэн суралцуулна. Элсэгч нь суралцах хугацаандаа хувцас, хүнс, байраар хангагдан төлбөргүй суралцахаас гадна амжилттай суралцсан тохиолдолд цэргийн мэргэжил эзэмшин офицерийн албанд шилжинэ.

ЗХЖШ, бусад төрийн цэргийн байгууллагуудын 30 хүртэлх насны ахлагч өөрийн харьяа байгууллагын зөвшөөрлөөр бакалаврын хөтөлбөрт элсэхдээ ЭЕШ-ын оноогоор бусад элсэгчидтэй ижил түвшинд өрсөлдөнө. ЭЕШ-ын шаардлагыг хангаагүй тохиолдолд элсэн суралцах боломжгүй.

Хөгжмийн урлаг хөтөлбөрт ур чадварын шаардлага хангасан, хөгжимчний мэргэжлийн дипломтой 25 хүртэлх насны хөгжимчин ахлагч болон иргэдийг элсүүлэн суралцуулна.

Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт 23 хүртэлх насны иргэдийг /эрэгтэй/ элсүүлэн цэргийн бага мэргэжил эзэмшүүлнэ. /Энэхүү хөтөлбөр нь төлбөргүй, суралцагчид нь цэргийн дүрэмт хувцас, байр, хоол, сургалтын зардлаар үнэгүй хангагдана/.

Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэлтийн шаардлага хангасан хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдыг ЗХЖШ-ын даргын цэргийн албанаас халсан тухай тушаал, анги, байгууллагын албан бичгийг үндэслэн элсүүлэн суралцуулж болно.

Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт эмэгтэй иргэдийг элсүүлэн суралцуулахгүй.

Гадаад улсад бүрэн дунд боловсрол эзэмшсэн Монгол Улсын иргэнийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын элсэлтийн ерөнхий шалгалттай дүйцэх шалгалт өгсөн тухай тодорхойлолтыг үндэслэн элсүүлнэ.

## ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

Элсэлтийн бүртгэлийг орон нутагт Монголын их, дээд сургуулиудийн консорциум тусгай журам, хуваарын дагуу, Улаанбаатар хот болон Дархан-уул, Орхон, Төв, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Сэлэнгэ аймаг, Багануур дүүрэгт цахим хэлбэрээр http://mndu.gov.mn/elselt хаягаар явуулна.

Улаанбаатар хот болон Дархан-уул, Орхон, Төв, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Сэлэнгэ аймаг, Багануур дүүрэгт элсэлтийн цахим бүртгэл 2017 оны 5 дугаар сарын 15 -ны өдрийн 08.00 цагт эхэлж, 7 дугаар сарын 03-ны өдрийн 15.00 цагт дуусгавар болж хаагдана.

Бүртгүүлэгч системд ЭЕШ-ын бүртгэлийн дугаар, нууц үгээ оруулснаар элсэх хүсэлтээ гаргана.

Системд амжилттай нэвтэрсэн үед системээс бүртгүүлэгчийн хувийн болон ЭЕШ-ын мэдээллийг дэлгэцэнд харуулах ба хүндрэлтэй асуудал үүссэн тохиолдолд элсэлтийн комисс болон Боловсролын үнэлгээний төвд хандаж шийдвэрлүүлнэ.

Хувийн мэдээллийг баталгаажуулсны дараа сонирхсон хөтөлбөрийнхөө талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

## ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ

Босго оноог хангасан бүртгүүлэгчдээс шалгаруулалт хийхдээ хавсралтад заасан шалгалтуудын харьцааг харгалзана. Жишээ нь: Тухайн сонгосон хөтөлбөрийн хоёр шалгалтын оноог 70:30 гэсэн харьцаагаар нэмнэ. Элсэгч нэгдүгээр хичээлд 640 оноо, хоёрдугаар хичээлд 520 оноо авсан гэж үзвэл таны нийлбэр оноо x=640*0,7+520*0,3= 604 оноо болно. Энэхүү хэмжээст оноо нь элсэгчийн ҮБХИС-д элсэх босго оноо болно.

Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт (АС, ЦХС-д) Улаанбаатар хот болон Дархан-уул, Орхон, Төв, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Сэлэнгэ аймаг, Багануур дүүргээс элсэгчдийг 7 дугаар сарын 08-нд Цэргийн төв эмнэлгийн цэргийн нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгт хамруулна.

## ДАРААХ ХӨТӨЛБӨРҮҮДЭД УР ЧАДВАРЫН НЭМЭЛТ ШАЛГАЛТ АВНА. ҮҮНД:

Хөгжмийн урлаг хөтөлбөрт элсэгчдээс сонсгол болон хөгжимдөх ур чадварын шалгалт авч, эдгээр чадварыг 100% гэж тооцон 70%-иас дээш амжилт үзүүлбэл тэнцэх шалгуурыг хангасан гэж үзнэ.

Ахлагчийн сургуулийн мэргэжлийн боловсролын хөтөлбөр, хөгжмийн урлаг болон үлээвэр хөгжмийн хөтөлбөрт элсэгчдээс ур чадварын шалгалтыг ҮБХИС-ийн элсэлтийн комисс Улаанбаатар хотод 2017 оны 7 дугаар сарын 08–ны өдрийн 14.00 цагт авна (шалгалт авах байр, танхимыг бүртгэлийн үед мэдэгдэнэ). Шалгалтын дүнг мөн өдрийн 20.00 цагт системд байршуулж нийтэд мэдээлнэ.

Орон нутагт аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Цэргийн штабаас эрүүл мэндийн үзлэг, бие бялдрын шалгуур үзүүлэлт, биеийн тамирын шалгалт авч тэнцсэн иргэдийг орон нутгийн элсэлтийн комисст хүлээлгэн өгнө.

### МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРТ ЭЛСЭГЧДИЙН ӨГӨХ БИЕ БЯЛДРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН НОРМАТИВ

| № | Бие бялдарын чанарууд | Дасгалын төрөл | Аргачлал | Тэнцүүлэх үзүүлэлт |
|---|---|---|---|---|
| 1. | Хүч | Дүүжинд суниах | Тоо | 12-оос дээш |
| 2. | | Гэдэсний таталт | Тоо | 56-аас дээш |
| 3. | Тэсвэр | 3000 метрт гүйх | мин | 12.30-аас дотогш |
| 4. | Хурд | 100 метрт гүйх | сек | 15.0-оос дотогш |

- Тайлбар: Дээрх 4 үзүүлэлтийн 2 ба түүнээс дээш дасгалыг биелүүлсэн тохиолдолд тэнцэнэ. 100 метр, 3000 метрийн гүйлтийн аль нэг дасгалд заавал тэнцсэн байвал зохино. Ахлагчийн сургуульд элсэгчид 165 см-ээс дээш өндөртэй, 60 кг-аас багагүй жинтэй байна. Цэргийн хөгжмийн сургуульд элсэх сурагчид нь бие бялдрын ерөнхий хөгжил хэвийн байх шаардлагыг хангана.
- Хэмжээст оноо тэнцсэн тохиолдолд гадаад хэлний шалгалт өгсөн эсэх, гүйцэтгэлийн хувиар байр эзлүүлж элсүүлнэ.Онооны дараалаар хөтөлбөр бүрээр цуваагаар байр эзлүүлж, хяналтын тоонд багтсан элсэгчдийн нэрсийг мэдээлийн самбарт байршуулна. Цэргийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр эрүүл мэндээр тэнцэхгүй нь тогтоогдсон, бие бялдрын бэлтгэлжилтийн шалгуур үзүүлэлтийг хангаагүй элсэгчдийг жагсаалтаас хасч, онооны дараалаар дараагийн бүртгүүлэгчид сонголтыг шилжүүлнэ.

## ЭЛСЭГЧЭЭР БҮРТГЭХ

Улаанбаатар хот болон Дархан-уул, Орхон, Төв, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Сэлэнгэ аймаг, Багануур дүүргээс бакалаврын хөтөлбөрт тэнцсэн элсэгчдэд 7 дугаар сарын 05-07-ны өдрийн, мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэгчдэд 7 дугаар сарын 09-ний өдрийн 08.00-17.00 цагт ҮБХИС-д суралцах эрхийн бичиг олгоно.

Заасан хугацаанд ирж, суралцах эрхийн бичгээ аваагүй бүртгүүлэгчийг суралцахаас татгалзсанд тооцож онооны дараалаар дараагийн элсэгчид сонголтыг шилжүүлнэ.

Бүртгэлийн хураамж 15 000 төгрөг байх ба бүртгүүлэгч нь эрхийн бичиг авахдаа дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Иргэний үнэмлэх /ахлагчийн үнэмлэх/
- ЭЕШ-ын батламж
- Боловсрол эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг
- Сурагчийн хувийн хэрэг
- БХЯ, ЗХЖШ-ын зөвшөөрөл, анги байгууллагын тодорхойлолт /зөвхөн ахлагч нарт хамаарна/
- 3х4 хэмжээний цээж зураг 4 хувь
- Төгссөн сургуулийн тодорхойлолт
- Системээс илгээсэн бүртгэлийн хуудас зэрэг материалуудыг битүүмжлэл сайтай хавтсанд хийж бүрдүүлсэн байна.

### ТАЙЛБАР: АХЛАГЧИЙН СУРГУУЛИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ХӨТӨЛБӨРТ ОРОН НУТГААС ТЭНЦСЭН ЭЛСЭГЧИД НЬ:

- 7 дугаар сарын 24-25-ны өдөр Улаанбаатар хотод хүрэлцэн ирж ҮБХИС-ийн элсэлтийн комисст бүртгүүлнэ.
- 7 дугаар сарын 26-ны өдөр Цэргийн төв эмнэлгийн цэргийн нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгт хамрагдана.
- 7 дугаар сарын 27-нд ур чадварын шалгалт давтан өгнө.
- 7 дугаар сарын 29-ны өдрөөс 8 дугаар сарын 27-ныг хүртэл хугацаанд цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдаж, цэргийн тангараг өргөнө.

## БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ОРОН НУТГААС ТЭНЦСЭН ЭЛСЭГЧИД НЬ:

Монголын их, дээд сургуулиудын консорциумын элсэлтийн комиссоос бакалаврын хөтөлбөрт суралцах эрх авсан элсэгчид 7 дугаар сарын 24-27-нд ажлын цагаар ҮБХИС-д өөрийн биеэр ирж бүртгүүлэх ба ажлын 5 өдөрт багтаан боловсролын хууль тогтоомж, ҮБХИС-ийн дүрэм, дотоод журам, зохион байгуулалт, сургалтын журамтай танилцаж, тухайн хичээлийн хагас жилд судлах “Хичээл сонголт“ хийх.

Суралцах эрх авсан боловч заасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр системийн бүртгэлд бүртгэлээ баталгаажуулаагүй элсэгчийг суралцахаас татгалзсан гэж үзэн суралцах эрхийг хүчингүйд тооцно.

Элсэлтийн цахим хуудас нь тогтмол ажиллагаатай нээлттэй үйлчилж элсэлттэй холбоотой мэдээллээр бүртгүүлэгчдийг хангана.

Элсэгчдэд бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулна.

**ХАРИЛЦАХ УТАС, ХАЯГ:**
**-Боловсрол, сургалтын хэлтэс: 453164, info@mndu.gov.mn**
**-Аюулгүй байдлын сургууль: 454132, mes@mndu.gov.mn**
**-Цэргийн хөгжмийн сургууль: 480168, moc@mndu.gov.mn**
**-Ахлагчийн сургууль: 450416, nco@mndu.gov.mn**
**- Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, Улаанхуаран /www.mndu.gov.mn/**

### БАКАЛАВРЫН БҮЛЭГ ХӨТӨЛБӨР, ҮНДСЭН ХӨТӨЛБӨР, ХАВСАРГА ХӨТӨЛБӨРҮҮД

| БҮЛЭГ ХӨТӨЛБӨР | ҮНДСЭН ХӨТӨЛБӨР | ХАВСАРГА ХӨТӨЛБӨР |
|---|---|---|
| Математик суурьтай хөтөлбөр- I | Ерөнхий цэргийн команд | - Соёл хүмүүжлийн ажилтан |
| | Эдийн засаг | - Цэргийн ар талын команд |
| | Менежмент | - Батлан хамгаалах салбарын менежмент |
| Математик суурьтай хөтөлбөр- II | Авто инженер | - Цэргийн авто, гинжит машины ашиглалт<br>- Хүнд машин механизмын ашиглалт |
| | Цэргийн инженер | - Барилга замын машины ашиглалтын инженер<br>- Уул уурхайн машины ашиглалтын инженер<br>- Автозамын барилга<br>- Барилга, инженерийн байгууламж<br>- Усны эрэл, хайгуул, ус хангалтын |
| | Артиллери | -Хэрэглээний математик |
| | Цэргийн зэвсэглэл | |
| | Системийн аюулгүй байдал | -Кибер аюулгүй байдал |
| Физик суурьтай хөтөлбөр | Зенитийн пуужин - автоматжуулалт | -Автоматжуулалт |
| | Зенитийн артиллери – Электроник | -Электроник автоматжуулалт |
| | Радио техникийн команд | -Радиоэлектроник |
| | Цэргийн холбооны инженер | - Цахилгаан холбоо<br>- Утасгүй холбоо |
| Гадаад хэл суурьтай хөтөлбөр | Олон улсын харилцаа | -Цэргийн гадаад харилцаа |
| Нийгмийн тухай мэдлэг суурьтай хөтөлбөр | Нийтийн удирдлага | |
| Хими суурьтай хөтөлбөр | Цэргийн хими хамгаалалт | -Хими технологи |
| Монгол хэл суурьтай хөтөлбөр | Хөгжмийн урлаг | -Цэргийн хөгжмийн удирдаач |

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ

# МЭДЭЭЛЭЛ

## Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, НИТХ-ын дарга Ц.Сандуй нарыг огцруулахаас хариуцлага тооцож эхлэх үү

*Ерөнхийлөгчийн сонгууль анх удаа дахин санал хураалтаар шийдэгдэхээр боллоо. АН-ын Х.Баттулга, МАН-ын М.Энхболд нар дахин санал хураалтад өрсөлдөнө. Гэхдээ СЕХ зургадугаар сарын 26-ны шөнө саналыг нэгтгэн зарлаж байснаа гэнэт зогсоосон, тэгээд үргэлжлүүлэхэд МАН-ын М.Энхболдын санал өсч, МАХН-ын С.Ганбаатарынх нам гацсан. Маргааш өглөө /2017.6.27/ нь Х.Баттулга тэргүүлсэн хэвээр, харин М.Энхболд хоёрдугаарт орж, С.Ганбаатар гуравдугаар байр руу ухарсан байв. Олон нийт, улс төрийн хүчнүүдийн аль нь ч М.Энхболдын энэ ялалтыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм. Тэр ялагдсанаас ялгаагүй. Зөвхөн М.Энхболд биш МАН энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдал хүлээж байгаа хэрэг. Энэ нь МАН-ын өнгөрсөн нэг жилийн туулж өнгөрүүлсэн замтай холбоотой юм.*

### Мэргэжлийн бус Засгийн газар байгуулав

УИХ-ын ээлжит сонгууль 2016 оны зургадугаар 29-нд болж, МАН-аас нэр дэвшсэн 65 хүн ялалт байгуулав. Ингэж бүтэн дөрвөн жилийн турш Монголын улс төрд захалж гүйсэн МАН төвийн тоглогч болоод буцаж ирэв. Ялалтын шөнөөс цээжээ дэлдээд эхэлсэн. Улмаар анхдугаар чуулган 2016 оны долдугаар сарын 5-нд болж, МАН-ын дарга М.Энхболдыг УИХ-ын даргаар сонголоо. АН-ын, МАН-ын хашир гишүүд М.Энхболдыг Ерөнхий сайд бус УИХ-ын дарга болсонд ихээхэн гайхаж буйгаа илэрхийлж байсан. Ерөөс ялсан намын дарга Ерөнхий сайд болж, хариуцлага, эрх мэдэл хоёрыг хамтдаа үүрч ирсэн. Энэ жишгийг орхиж М.Энхболд УИХ-ын даргын суудал руу зүтгэсэн нь энэ. УИХ-ын гишүүдийн 80 гаруй хувь дэмжээд хүссэн суудалд нь суулгав. Яг эндээс л М.Энхболдын өнөөдөр Ерөнхийлөгчийн сонгуульд газардах шалтгаан нөхцөлийн суурь тавигдсан юм. Ингээд 2016 оны долдугаар сарын 8-ны нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдаар Ж.Эрдэнэбатыг томиллоо. МАН-ын даргын идэвхтэй дэмжлэгээр Ерөнхий сайд болсон Ж.Эрдэнэбатын гаргах шийдвэр олон хүлээлтэд хариу өгөх учиртай болов. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат 2016.7.21-нд УИХ-д Засгийн газрыг бүтцээ оруулж батлуулав. Үүгээр Монгол Улсын Засгийн газар 13 яам, 16 сайдтай байхаар болсон юм. Мөн энэ чуулганаар Засгийн газар дэд сайдтай байна гэж батлуулав. Энэ мэдээ олон нийтийг гонсойлгосон. Учир нь энэ үед МАН-ын гол амлалтуудын нэг болох дан дээлтэй, Мэргэжлийн Засгийн газар байгуулахыг олон нийт чих тавин хүлээж байлаа. УИХ-ын 2016.7.22, 29-ний чуулганаар Мэргэжлийн Засгийн газрын сайд нарын томилгоог баталлаа. Ихээхэн хүлээлт дунд бүрдсэн Ж.Эрдэнэбатын тэргүүлсэн Мэргэжлийн Засгийн газрыг олон нийт тийм ч таатай хүлээж авсангүй. Учир нь нэр бүхий хэд хэдэн сайд давхар дээлтэй, мэргэжлийн бус болж таарсан юм. Үнэмлэхүй эрх мэдэлтэй МАН энэ шүүмжлэлийг тоосонгүй. Ингэж МАН-ын амлалт эхнээсээ нурсан юм.

### Хийтэй томилгоонууд

МАН-ын дарга М.Энхболд УИХ-ын дарга болж, Ерөнхий сайдаар өөрийн хүн Ж.Эрдэнэбатыг томилуулснаар хийтэй томилгоо ар араасаа цуварсан. Хэдийгээр томилгооны эрх мэдэл М.Энхболдод төвлөрч байсан гэх боловч Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын дарга нар гээд тал талаасаа томилгоонд хутгалдсан юм. Засгийн газарт ч ЗГХЭГ-ын дарга, Сангийн сайд, ХХАА-н сайд, ХНХ-ын сайд, Эрүүл мэндийн сайд нарыг тойрсон элдэв шүүмжлэл өрнөсөн. Одоо ч тасраагүй. Ингээд яамдын газар хэлтсийн дарга, агентлагийн дарга нарын томилгоонуудыг эргэж харвал дээрх амлалт хэрхэн нурсныг харж болно. Түүнчлэн Улаанбаатар хотын удирдлагуудыг томилохдоо нийтийн санаа бодол, ядаж МАН доторх үзэл бодлыг ч харгалзаагүй гэдэг. НИТХ-ын даргаар Ц.Сандуйг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар Су.Батболдыг томиллоо. Энэ томилгоо тааруухан сонголт байсныг хүн бүр л хэлж байна.

### "Мэргэжлийн" Засгийн газар МАН–ын амлалтыг нураав

Чухамдаа МАН-ын нэр хүнд Ж.Эрдэнэбатын тэргүүлсэн Засгийн газрын нуруун дээр яваа тэд ойлгодог болов уу. Энэ Засгийн газар ингэж асуумаар болтол ажиллаж байгаа.

2016 оны УИХ-ын сонгуулийн үеэрх МАН-ын амлалт үнэндээ л гоё.

-Хүүхдийн 20 000, оюутны 70 200 төгрөгийг үргэлжлүүлэн олгоно.

-Татвар нэмэхгүй. Шинэ төрлийн татвар нэмж бий болгохгүй.

-Төсвийн зардлыг танаж, алдагдлыг бууруулна.

Үүнээс гоё амлалтууд ч зөндөө бий. Энд дурдсан нь Ж.Эрдэнэбатын Засгийн газрын шууд эсрэгээр биелүүлсэн нь юм. Өнөөдөр хүүхдийн 20 000, оюутны 70 200 төгрөг байхгүй болсон. Нийтдээ долоон төрлийн татвар нэмсэн. Үүнд архи тамхи, шатахуунаас гадна ард түмний унаа болсон "Приус" машины таварыг 50 хувиар нэмэхээр болсон юм. Шинээр татварууд бий болгосон. Хадгаламжийн хүүнээсээ татвар өгөх зэрэг Монголд байгаагүй татварыг Мэргэжлийн Засгийн газрын үед бий болгов. Үүнээс гадна төсвийн тодотголын үеэр нийтэд ил болсон нэг асуудал бий. Засгийн газар нууцаар хэд хэдэн концессын гэрээ байгуулсан нь ил боллоо гэээд бөөн бужигнаан болсон. УИХ дахь МАН-ын гишүүд хүртэл гэнэт мэдээд ихээхэн сандарч байсныг санаж байна. Эднээс хамгийн ихээр дуулиан тарьсан нь МАК-ийн гэрээ байдаг юм.

### 60 тэрбумыг босгох тухай бичлэг

Алдарт 60 тэрбумыг босгох тухай ярианы бичлэг анх 2016 оны УИХ-ын сонгуулийн санал хураалтын өмнөхөн ил болж байлаа. Сонгууль болж, МАН ялсны дараа "...Эвлүүлэг байжээ" гэсэн хуулийнхны дүгнэлт гарсан байдаг. Түүнээс хойш таг чиг байсаар Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөхөн бүхэл бүтэн 90 минутын бичлэг задрав. Зүй нь, МАН ийм асуудалд үнэн ч, худал ч нэр холбогдсон М.Энхболдын нэрийг Ерөнхийлөгчид дэвшүүлэдэг нь нэг алдаа болсон. Түүний оронд Ө.Энхтүвшин, эсвэл Ц.Нямдорж нэр дэвшсэн арай өөр дүн үзүүлнэ. Үүнийг ажиглагчид, судлаачид хэлээд байгаа юм.

ИргэнГ.Доржзодовыгхамгаалалтад авахаар хөөцөлдөөд барьж чадалгүй Америкийн иргэний гэрт оруулчихав. Ингээд хэд хоног гадаа нь сахисан байх. Нөгөөх Г.Дожзодов нь "...Ж.Мөнхбат намайг саунд дуудаад сая доллар өгье. Аваад дуртай улс руугаа яв гэсэн" гээд мэдэгдчихэв. Энэ мэтээр МАН-ынхан өөрсдөө 60 тэрбумын бичлэгийн асуудлыг гал дээр тос хийх шиг өрдсөн.

### Сурталчилгааны бялуурал

Сурталчилгааны үеэр 60 тэрбумын тухай90минутынярианаасэхлээдхууль хүчний байгууллагын удирдлагууд М.Энхболд даргад бараалхаж байга бичлэг нийтийн хүртээл болсон. Мөн Хотын фракцынхан УИХ-ын дарга М.Энхболдод уутай "юм" бариад золгодог бичлэг гарч ирэв. Тэдний дунд нэгэн анхаарал татсан хүн байсан нь одоогийн Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан байсан. Үүнээс гадна удтал хүлээлгэсэн мэтгэлцээн олны сэтгэлд хүрэлгүй, тавилттай жүжиг боллоо гэсэн. Энэ мэтгэлцээний үеэр МАН-ын дарга М.Энхболдод тавьсан асуултуудыг М.Энхболд даргын хамаатан, УИХ-ын гишүүн нэгэн эмэгтэй бэлдэж өгсөн гэж байна. Түүнчлэн М.Энхболдын сонгуулийн сурталчилгаанд Монголын урлаг, спортын бүх "од" хүмүүс оролцож, зарим нь М.Энхболдын хэлснээр яваад амжилтад хүрлээ гэх зэргээр алиа марзан PR хийсэн нь бас л алдаа болж хувирсан.

### Хариуцлагыг хэн хүлээх вэ

М.Энхболдод ард түмний санал өгсөн байдал бол МАН-ын өнгөрсөн нэг жилд хэр зэрэг, ямар байсныг л дүгнэсэн хэрэг юм. Тиймээс МАН-ын дарга М.Энхболдоос өөрөөс нь, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, НИТХ-ын дарга Ц.Сандуй, сонгуулийн сурталчилгааны үеэр алиа марзнаар дүүрэн сурталчилгаа явуулсаар дуусгасан PR зөвлөхүүд гээд олон хүний "хүч хөдөлмөр", суурь дэвсгэрээс болсон байгаа юм. Одоо хариуцлагаа хэн яаж хүлээх вэ. МАН-ын дотоодод энэ талаар нэлээд ширүүн ярьж эхлээд байна. Нуугаад байхааргүй болсон байна. Юутай ч эх сурвалжуудын мэдээллээр Засгийн газар огцорч магадгүй байдал нэгэнт үүссэн байна. НИТХ-ын дарга Ц.Сандуйгаас эхлээд ажлаа өгч, хариуцлагаа хүлээх тухай яригдаад эхэллээ.


## УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛЬД 2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД БАКАЛАВРЫН ОЮУТНЫ ЭЛСЭЛТ

**НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Улаанбаатарын Их Сургууль (УБИС) нь 2017 онд оюутан элсүүлэх БШУ-ны сайдын 2013 оны 3-р сарын 18-ны А/792 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам" –нд нийцүүлэн боловсруулав.

1.2 УБИС-ийн Элсэлтийн Комисс нь (ЭК) Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэр дэх өөрийн сургуулийн байрандаа болон хөдөө орон нутаг дахь итгэмжлэгдсэн бие төлөөлөгч болон Монголын Их Дээд Сургуулиудын Консерциум (МИДСК)-аар дамжуулан элсэгчдийн хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, элсүүлэх ажлыг зохион байгуулна.

1.3 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, УБИС-ын Удирдах зөвлөлийн баталсан оюутны хяналтын тоонд нийцүүлэн өөрийн сургуулийн материаллаг бааз, багшлах бүрэлдэхүүний хангамж, хүчин чадал зэргээс хамааран сургалт явуулах тусгай зөвшөөрөлд заагдсан индекс бүхий мэргэжлийн чиглэлээр оюутан элсүүлнэ.

1.4 Энэхүү журам болон элсэлт авах мэргэжлийн хөтөлбөр, элсэлтийн ажлын зохион байгуулалттай холбоотой нэмэлт мэдээллийг УБИС-ийн www.usu.edu.mn гэсэн вэб хуудсанд байрлуулна.

**ХОЁР. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА**

2.1 УБИС-д элсэгч нь бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой байх ба тухайн хөтөлбөрт харгалзах суурь хичээлээр 2015, 2016, 2017 онд ЭЕШ өгсөн байна.

2.2 Бүртгүүлэгчийн нийт оноог хүснэгтэнд заасан шалгалтуудын харьцааг харгалзан тооцож гаргана. Тухайлбал, хөтөлбөр хоёр шалгалттай ба хоёр шалгалтын оноог 70:30 харьцаагаар нэмэх буюу "Суурь" шалгалтанд авсан оноог 0.7-оор, "Дагалдах" шалгалтанд авсан оноог 0.3-аар үржүүлж нэмнэ. Нийт оноо нь Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам (БСШУСЯ) болон тус сургуулийн Удирдах зөвлөлийн баталсан босго оноонд хүрсэн байна. ( хүснэгтэнд зааснаар)

2.3 Гадаадын иргэн УБИС-д элсэх тохиолдолд Бакалаврын сургалт эрхлэхэд баримтлах журмын 6.20, 6.21, 6.22 заасан болзлыг хангасан байна.

**ГУРАВ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ**

3.1 Бүрэн дунд болон түүнээс дээш боловсрол эзэмшсэн, элсэлтийн ерөнхий шалгалтанд 400 болон түүнээс дээш оноо авсан бүртгүүлэхийг хүсэгчдийг 2017 оны 06 сарын 15-аас 2017 оны 07-р сарын 8-ны өдрүүдэд www.elselt.usu.mn хаягаар болон Улаанбаатарын Их сургуулийн байранд бүртгэнэ.

3.2 Орон нутгаас элсэгч нь тухайн аймагтаа МИДСК, сургуулийн бие төлөөлөгчдөд бүртгүүлэхээс гадна www.elselt.usu.mn хаягаар болон Улаанбаатарын Их сургуулийн байранд хүрэлцэн ирж бүртгүүлж болно.

3.3 Элсэхийг хүсэгчид дараах бичиг баримтыг бүрдүүлж ирнэ.

- Бүрэн дунд боловсролын үнэмлэх, түүнтэй адилтгах бичиг баримт
- Сурагчийн хувийн хэрэг
- Иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар
- 3*4 хэмжээтэй 2 хувь цээж зураг
- Ерөнхий шалгалтын батламж
- Төрийн сангийн зээл, тусламжаар суралцах бол холбогдох бичиг баримтыг авч ирэх

3.4 УБИС-д ЭЕШ-ын оноог баримтлан оюутан элсүүлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт элсэлт авах бүртгэл 2017 оны 08-р сарын 26-аас 2017 оны 08-р сарын 31-ны өдрүүдэд сургуулийн байранд явагдана.

**ДӨРӨВ. ЭЛСЭЛТИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ НӨХЦӨЛ, ТЭТГЭЛЭГ**

4.1 БСШУСЯ-ны сайдын холбогдох тушаалд нэр заасан улсын болон олон улсын олимпиадад оролцсон, БСШУСЯ-аас тавигдах ЭЕШ-ын босго оноог хангасан ЕБС төгсөгчийг тухайн чиглэлээр БСШУСЯ-ны лавлагаа болон холбогдох баримт бичигт үндэслэн шууд элсүүлнэ.

4.2 2016-2017 оны хичээлийн жилд олон улсын болон улс бүсийн чанартай мэргэжлийн олимпиадад 1-4 дүгээр байр, шагналт байр эзэлсэн элсэгч УБИС-д элсэхээр бүртгүүлсэн тохиолдолд тухайн амжилтыг баталгаажуулах бичиг баримтыг үндэслэн "Элсэх болзолыг хангасан" нөхцөлд онооны дараалал харгалзахгүй элсүүлнэ.

4.3 Энэхүү журмын 4.1, 4.2-т заасан хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцах болзол хангасан элсэгч мэргэжил сольж суралцахыг зөвшөөрөхгүй.

4.4 Сургалтын төлбөрийн дараах хөнгөлөлт, тэтгэлэг эдлэнэ.

1. Зургаан улирал дараалан "А" үнэлгээтэй сурсан оюутанд ректорын нэрэмжит тэтгэлэг
2. Төрийн сангийн бүх төрлийн тэтгэлэг
3. БНСУ-ын Ази, Номхон далайн орнуудын оюутан залуучуудын нэрэмжит тэтгэлэг
4. Тайвань-Монголын нийгэмлэгийн тэтгэлэг
5. Японы "Сүмитомо" корпорацийн тэтгэлэг
6. Улаанбаатарын их сургуулийн хүндэт доктор, БНСУ-ын Жан Сам Хён профессорын нэрэмжит тэтгэлэг
7. Төгсөгчид АНУ-ын Калифорни мужийн "Lincoln"-н Их сургуульд TOEFL-н шалгалтгүйгээр элсэн суралцах
8. Гадаад хэлний судлаач, орчуулагч мэргэжлээр сайн суралцаж буй оюутнуудыг тухайн орны их дээд сургуулиудад 6 сараас 1.5 жилийн хугацаатай оюутан солилцоонд хамруулдана
9. БНХАУ-ын ЭСЯ-ны дэмжлэгэтэйгээр жил бүр өөрийн сургуулийн оюутнуудаас Хө Нань мужийн Технологийн Их Сургууль руу 6 сарын хугацаатай сар бүр 2350 юаний тэтгэлэгтэй суралцах
10. Японы Хирошима их сургуульд 6 сараас 1 жилийн хугацаатай 100%-ийн тэтгэлэг авахаас гадна сар бүр 80,000 иений авах тэтгэлэгтэй суралцах
11. Японы Хирошима их сургуульд богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдан сар бүр 20,000 иений тэтгэлэгтэй суралцах
12. БНСУ-ын Сүньчоньхян болон Дэгү кибер их сургуулийн тэтгэлэг
13. Захирлын нэрэмжит тэтгэлэг
14. Ерөнхий шалгалтын онооноос хамааран сургалтын төлбөрт үзүүлэх хөнгөлөлт:

| ЕШ оноо | Хөнгөлөлт |
|---|---|
| 780-800 | -100% |
| 750-780 | -80% |
| 700-750 | -50% |

**ТАВ. БУСАД**

6.1 Цахим бүртгэл явагдаж байх үед бүртгүүлэгчдэд зөвлөгөө өгөх үйл ажиллагааг Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэр дэх өөрийн сургуулийн байрандаа болон элсэлтийн бүртгэлийн систем www.elselt.usu.edu.mn facebook, утас, цахим шуудан ашиглан явуулна. Мөн дэлгэрэнгүй мэдээллийг www.usu.edu.mn сайтын элсэгч булангаас авах боломжтой.

**2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ЭЛСЭЛТ АВАХ МЭРГЭЖЛҮҮД**

| № | Индекс | Хөтөлбөрийн нэр | | Мэргэжлийн нэр | Суурь шалгалт /70%/ | Дагалдах шалгалт /30%/ | Босго оноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | D023203 | Утга зохиол судлал | 1 | Утга зохиол судлал | Монгол хэл Англи хэл Орос хэл | Монголын түүх Нийгмийн тухай мэдлэг Монгол хэл Англи хэл Орос хэл | 400 |
| 2 | D023201 | Хэл, уран зохиол | 2 | Хэл, уран зохиол | | | |
| 3 | D032101 | Сэтгүүл зүй | 3 | Сэтгүүл зүй | | | |
| 4 | D023101 | Гадаад хэлний орчуулга | 4 | Англи хэлний орчуулга | | | |
| | | | 5 | Солонгос хэлний орчуулга | | | |
| | | | 6 | Япон хэлний орчуулга | | | |
| | | | 7 | Хятад хэлний орчуулга | | | |
| 5 | D022203 | Олон улс орон судлал | 8 | Археологи-япон судлал | Монголын түүх Нийгмийн тухай мэдлэг Монгол хэл Англи хэл Орос хэл Газар зүй | Монголын түүх Нийгмийн тухай мэдлэг Математик Монгол хэл Англи хэл Орос хэл Газар зүй | 400 |
| | | | 9 | Археологи-хятад судлал | | | |
| | | | 10 | Археологи-солонгос судлал | | | |
| 6 | D022202 | Археологи | 11 | Археологи | | | |
| 7 | D021304 | Түүх соёлын дурсгалт зүйлсийн сэргээн засварлалт | 12 | Түүх соёлын дурсгалт зүйлсийн сэргээн засварлалт | | | |
| 8 | D022203 | Олон улс орон судлал | 13 | Түүх-япон судлал | | | |
| | | | 14 | Түүх-хятад судлал | | | |
| | | | 15 | Түүх-солонгос судлал | | | |
| 9 | D022201 | Түүх | 16 | Угсаатны зүй | | | |
| | | | 17 | Аялал жуулчлал | | | |
| 10 | D031201 | Улс төр судлал | 18 | Улс төр судлал | | | |
| 11 | D031402 | Социологи | 19 | Социологи /олон нийттэй харилцах ажилтан/ | | | |
| 12 | D073103 | Хот ба бүс нутгийн төлөвлөлт | 20 | Хот ба бүс нутгийн төлөвлөлт | | | |
| 13 | D041303 | Нийтийн удирдлага | 21 | Нийтийн удирдлага /Төрийн захиргааны удирдлага/ | | | |
| 14 | D061201 | Компьютерийн сүлжээ | 22 | Сүлжээний аюулгүй байдал | Математик Газар зүй Физик Хими Биологи | Монголын түүх Нийгмийн тухай мэдлэг Математик Монгол хэл Англи хэл Орос хэл Газар зүй Хими Биологи Физик | 400 |
| | | | 23 | Сүлжээний администратор | | | |
| 15 | D071401 | Электрон системийн автоматжуулалт | 24 | Электрон системийн автоматжуулалт инженер | | | |
| | | | 25 | Үйлдвэрлэлийн автоматжуулалтын инеженер | | | |
| 16 | D053302 | Хэрэглээний физик | 26 | Сэргээгдэх эрчим хүчний инженер | | | |
| | | | 27 | Физик электроникийн инженер | | | |
| | | | 28 | Стандартчиллын инженер | | | |
| 17 | D051101 | Биологи | 29 | Биологи | | | |
| 18 | D071201 | Байгаль орчныг хамгаалах технологи | 30 | Байгаль орчны нөхөн сэргээлт | | | |
| 19 | D053101 | Хими | 31 | Хүрээлэн буй орчны химич | | | |
| | | | 32 | Хими технологич | | | |
| | | | 33 | Эмийн химич | | | |
| | | | 34 | Аналитик химич | | | |
| | | | 35 | Органик бус химич | | | |
| | | | 36 | Эрдэс, шинэ материалын химич | | | |
| 20 | D054102 | Хэрэглээний математик | 36 | Эдийн засгийн математик загварчлал | | | |
| 21 | D061301 | Компьютерийн ухаан | 38 | Компьютерийн программ хангамж | | | |
| | | | 39 | Компьютерийн график дизайн | | | |
| 22 | D041301 | Бизнесийн удирдлага | 40 | Бизнесийн удирдлага | | | |
| | | | 41 | Чанарын менежмент | | | |
| 23 | D041101 | Нягтлан бодох бүртгэл | 42 | Нягтлан бодох бүртгэл | | | |
| 24 | D031101 | Эдийн засаг | 43 | Эдийн засаг | | | |
| 25 | D053205 | Геофизик /Одон орон судлал/ | 44 | Геофизик /Одон орон судлал/ | | | |

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 5-р хороо "Монгол кино" үйлдвэрийн баруун хойно.
Утас: 11-456360, 11-453567, 96157253
Email хаяг: info@usu.edu.mn
Цахим хуудас: www.usu.edu.mn

ОНЦЛОХ ХУУДАС

Õýí íü õýí áý?

# Муулуулах тусам өнгө ордог Н.НОМТОЙБАЯР



..Дорнод-МАК нүүрсний уурхайгаа түшиглэн нефть химийн үйлдвэр байгуулахаар ТЭЗҮ боловсруулж бэлэн болгосныг нефтьчид хийгээд химичид талархаж хүлээж авсан. Тэгээд ч, МАК мянган мянган ажлын байрыг бий болгож, байгуулсан үйлдвэр, уурхай нь Монголын нэр хүндийг дэлхийд гаргаж яваа учраас тэр. Ганцхан жишээ дурьдахад, Дорноговь аймгийн Даланжаргалан суманд өндөр чанарын цементийн үйлдвэр барьж ашиглалтад оруулсныг уншигч та санаж буй нь лавтай...

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн сайд Н.Номтойбаяр нийгмийн сонирхлын төвд байхаа хэдийнэ больсон. Элдэв шалдав, эрээвэр хураавар зүйл сонирхдог бүлэглэлийнхний хувьд уншсаар байгаад өнцөг булан нь элэгдэж хуучирсан ном болж хувирсан гэж хэлж болно. Харин бүхнийг анхааралтайяа ажигладаг, бусдын хөдөлмөр зүтгэлийг олж хардаг нөхдүүдэд тэрбээр хүлээж хүлээж бараа нь хардаг арав хоног тутмын шинэ сэтгүүл хэвээр. Үнэндээ нас залуу, цус шингэн, улс төрд ногоон гэрлээр орж ирсэн, цөс ихт түшээгийн хаагуур зугаалсан, төрийн ордонд хэний өөдөөс цор цор хийсэн зэрэг нь хэн бүхний сонирхлыг татдаг байлаа, нэг хэсэг. Эл зан заримдаа намд нь ч хэрэг болж ирснийг үгүйсгэх аргагүй. Ер нь тэр цөстэй эр л дээ. Буриад цустайг ч хэлэх үү. Харин эдүгээ өмнөхөөсөө тэс өөр Номтойбаярыг харж болно. Дөрвөн жилийн өмнөх дүр зургаас бараг л юу ч үлдээгүй гэж хэлж болно. Эр хүн ухаан сууж, төлөвшинө гэдэг иим байдаг аж. Улстөрчийнх нь хувьд шүү дээ. Шулуухан хэлэхэд, муулах тусам өнгө орж гялалзана гээч тэр. Эдүгээ түүнийг нийгэм муулж, нүднийхээ булангаар сонжиж харах бус санаачилсан, боловсруулсан, ажлын хэсэгт нь орж ажилласан хуулийн төслүүд нь УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдан иргэдийн өдөр тутмын амьдралд нөлөөлөөд ирэхээр төр зөв хүнд нийгмийн салбарыг атгуулжээ хэмээн дүгнэх болсон байна лээ. Ард түмэн итгэл өгнө гэдэг улстөрчдийн хувьд тэр бүр олдоод байдаггүй хүндлэл юм. Хэл ус, төгссөн сургууль, харсан үзсэн нь ч нөлөөлдөг байх. Ямартай ч хариуцаж буй салбараа нэг л өөр зарчмаар удирдан чиглүүлж байгаад нь нийгмийн хамгааллынхан сэтгэл хангалуун байцгаадаг. Иим нэг эрхэм Дорнод түмний төлөөлөл болон УИХ-д сууж буй. УИХ-ын 15 дугаар тойрог УИХ-д хоёр мандаттай. Н.Номтойбаяраас гадна Ц.Болорчулуун гэж гишүүн бий. Түүний талаар ирэх долоо хоногт өгүүлэх учраас нэрийг нь дурьдаад орхиё.

## Сөрөг тагнуулаас улс төрд

Түүний намтар бусдынхаас сонирхолтой. Төгссөн сургууль, эзэмшсэн мэргэжил нь улс төрөөс хол хөндий байлгаж чаддаг ч мань хүний хувьд сөрөг тагнуулын офицерээс улс төрд хөл тавьсан анхны төрийн түшээ байж мэднэ. Дэлхийн түүхэнд энэ албанаас улс төрд хөл тавьсан ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинээс тохиолдол хэр олон байдгийг би хувьдаа хэлж мэдэхгүй. Н.Номтойбаяр морь жилтэй. Тодруулбал, 1978 оны долдугаар сарын 2-ны өдөр Б.Нямтайширын ууган хүү болон мэндэлсэн. УИХ, Засгийн газрын гишүүн, Н.Номтойбаяр АНУ-ын Индиана мужид Вальпаресогийн их сургуулийн улс төрийн ангийг дүүргэсэн бол Герман улсад Берлин Хэрэглээний шинжлэх ухааны чиглэлээр мастерын зэрэг хамгаалжээ. Ажил амьдралынхаа гараа нэгэн цагт аавынхаа ажиллаж байсан Тагнуулын ерөнхий газрын сөрөг тагнуулын хэлтсээс эхэлсэн аж. Харин түүний улс төрд хөл тавьсан түүхийн тухайд нийгэм сайн эцгийн нэр нөлөө хэмээдэг ч чухамдаа мань хүний өөрийнх нь гаргасан шийдвэр байсан юм билээ. Энэ талаараа "Би гадаад тагнуулын газар байж байгаад яах ч аргагүй ажиллахад үнэхээр хүнд хэцүү болоод л өөрөө өргөдөл өгөөд гарсан. Хүмүүс бол халагдсан гэж ярьдаг, тийм юм бол огт байхгүй. Харин ч гавьяа шагнал аваад явж байсан. Гэхдээ өөрөө өргөдөл өгөөд гарсан. Тэр нь юу гэхээр Намбарын Энхбаяртай холбоотой л асуудал. "МАК"-ийг шалгах хөдөлгөөн өрнүүлж байлаа.

Тэгээд л бага насны мөрөөдлөөрөө сонгосон тавилангаа орхиход хүрсэн. Манай аавын бие тааруухан эмчилгээнд явчихсан. Хэцүү үе байсан. Тэгээд л за за, тэгвэл магистраа хийчихээд улс төр лүү алхах цаг иржээ гээд л шийдвэрээ гаргаж байсан" хэмээн сэтгүүлч бүсгүйд сэтгэлийнхээ үгийг дэлгэсэн нь бий. Түүний эл шийдвэр алдаа болоогүй. Цаг хугацааны хувьд ч. Тэр үед МАН өнөөдрийнх шиг хүчтэй байгаагүй. Шулуухан хэлэхэд, УИХ-д цөөн болович суудал авахын төлөө байдгаа шавхаж байх үед дөнгөж улс төрд хөл тавьсан "аавын эрх хүү" /2012оны УИХ-ын сонгууль/ намдаа суудал чирсээр гарч ирсэн юм. Удалгүй МАН-ын Нийгмийн ардчилал залуучуудын холбоог тэргүүлээд зогсохгүй намын бага хурлын гишүүн улмаар Шинэчлэлийн Засгийн газарт Нийгмийн хамгааллын дэд сайдаар томилогдсон түүхтэй. Гэхдээ Номтойбаяр улс төрийн албан тушаалуудыг ногоон гэрлээр хашсан шигээ нийгмээс тийм хэмжээний хатуу үгийг сонсч яваа улстөрч. Өөрөө ч өөрийнхөө хэмжээнд цор цор хийгээд зүгээр байдаггүй. Зарим зүйлийг харсан ч хараагүй юм шиг өнгөрүүлдэг бөөрөнхийлдөг зан түүнд дутагддаг юм. Энэ бол улс төрч хүнд байх ёстой чанаруудын нэг юм гэнэ лээ. Нөгөөтэйгүүр, Н.Номтойбаярыг хүний мөс сайтай улстөрч гэж дүгнэж болохоор. Намынх нь байр шатчихсан тэвдэж явахад тэрбум төгрөг хандивлаж байсныг МАН мартаж болохгүй. Түүн шиг тэрбум төгрөг бариад зогсч байсан гишүүн тэр үед хэд байсан билээ.

## Монгол Улс нефтийн үйлдвэртэй болно

Уг нь энэ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын мөрөөдөл. Түүнийг улс төрд хөл тавихаас өмнө ажиллаж байсан МАК корпораци түүнийг нь гүйцэлдүүлнэ гэдэгт мөрий тавихад ч алдах юмгүй. Учир нь тэрбээр Дорнод-МАК нүүрсний уурхайгаа түшиглэн нефть химийн үйлдвэр байгуулахаар ТЭЗҮ боловсруулж бэлэн болгосныг нефтьчид хийгээд химичид талархаж хүлээж авсан. Тэгээд ч МАК мянга мянган ажлын байрыг бий болгож, байгуулсан үйлдвэр, уурхай нь Монголын нэр хүндийг дэлхийд гаргаж яваа учраас тэр. Ганцхан жишээ дурьдахад, Дорноговь аймгийн Даланжаргалан суманд өндөр чанарын цементийн үйлдвэр барьж ашиглалтад оруулсныг уншигч та санаж буй нь лавтай. Хамгийн их бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг Өмнийн говьд хийснээрээ, МАК говийн ард түмэнд танил болсон. Үүгээрээ Н.Номтойбаяр өмнийн говиос УИХ-д нэр дэвшсэн ч гараад л ирэх байлаа. Харин мань хүн дорнод түмнийг сонгосон байдаг. Учир нь нэгэн цагт тодруулбал, 1990 онд МАК-ийн Ерөнхийлөгч Б.Нямтайшир Дорнод аймгаас бизнесийн гараагаа эхэлж, хөл дээрээ боссон гэдэг. Гэр бүлд нь өгөөж буянаа харамгүй хайрласан нутаг учраас сонгосон хэрэг. Монголчууд ачыг хариулах учиртай хүн гэж ярьдаг даа. Тэр утгаараа өдгөө хүү нь ач санан Дорнодын талыг хөгжүүлэхийн төлөө сэтгэл оюунаа юүлж яваа. Тэр хэрээр тойргоо хангалттай "усалж" ирсэн. Түүн шиг байнга тойрог руугаа харайлган, тийн зорих бүрийдээ ганзага дүүрэн очдог УИХ-ын гишүүн ховор биз ээ. УИХ-ын шинэхэн гишүүд, ер нь хууччуул ч ялгаагүй сонгогдсон эхний хоёр жил тойргоо бараг л мартдаг гэмтэй. Тэгсэн ээ, сонгууль дөхөхөөр нутгаа, тойргоо санан өдөр шөнөгүй довтолгодог доо. Мань хүнд харин тийм зан байхгүй. Байсхийгээд л Дорнод руу давхиж, тойргийнхоо иргэдтэй уулзан тэдний амьдралыг өөд татахын төлөө зургаа дахь жилдээ зүтгэж яваа.

Маш олон янзын төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байдаг. Түүний цахим хуудас руу ороход энэ бүхэн илхэн харагддаг. Дорнодыг нутгийн хөгжил тэр тусмаа хөгжлийн гарцаа хэмээн тодорхойлж буй хил орчмын аялал жуулчлалыг бүрэн утгаар нь хөгжүүлж, тэндээс орж ирэх мөнгөн урсгалыг орон нутагтаа шингээх тухайд тэрбээр их зүйлийг бодож тунгааж, төлөвлөжээ. Орон нутагтаа хийж хэрэгжүүлсэн ажлыг нь мөнгөн дүнгээр хэмжих юм бол овоо хэдэн тэг бичих хэрэгтэй болох байх. Шинээр байгуулагдаж буй Зүүн бүсийн асрамжийн газар ч түүний нэртэй холбогдож таарна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төв, сумдад барьж ашиглалтад оруулсан болон эдүгээ баригдаж байгаа ахмадуудад зориулсан сувилалаас гадна аймгийн төвийн орон сууцны хорооллуудын газар доорхи байгууламжийн шинэчлэл, аймгийн төвийн цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх хөрөнгийг шийдвэрлүүлсэн, зарим сумын сургууль цэцэрлэгийн барилгын шинэчлэл гээд хийсэн, санаачилсан олон ажлыг нь нэрлэж болно. Юутай ч миний өмнө түүний орон нутагтаа хийж хэрэгжүүлсэн ажил гээд 46 хуудас тайлан байна. Үнэндээ түүнийг эргүүлж харах зав олдоогүй тул нүдэнд туссанаа тойм маягаар өгүүлэхэд иим байна. УИХ, Засгийн газрын гишүүн Н.Номтойбаяр аймаг, орон нутгаа хэрхэн хөгжүүлэх тухайд ч уулзалт, хэлэлцүүлгийг хэд хэдэн удаа зохион байгуулж, тэндээс гарсан саналыг ажил хэрэг болгохын төлөө зүтгэж яваа төрийн түгээ гэдгийг дахин онцлоё. Тэрбээр сайд болсон хэдий ч амралтын өдрөөр тойрог руугаа давхиастай. Утсаар ярих тоолонд Дорнодод, тойрогтоо, яг одоо Баяндун сумаас гарч явна.

Гурван цагийн дараа залгаарай, тэр үед Цагаан-Овоо орсон байх вий гэнэ. Н.Номтойбаяр сайд өнгөрсөн нэг жилийн хугацаанд өөрийн харьяалал бүхий сумдаараа тойрч иргэдтэйгээ уулзалт хийсэн бол тавдугаар сарын сүүлээс баг, хот айлаар орж УИХ-ын чуулганаар хэлэлцэж буй асуудал, орон нутгийн хүрээнд гишүүнийхээ зүгээс хийж буй ажил, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны сайдын хувьд санаачилж УИХ-д өргөн барьсан хуулийн төсөл эдүгээ хэрэгжиж буй хуулиудын талаар ярьж, таниулж, шинээр хэрэгжих хуулиудыг сурталчилж, иргэдтэй санал солилцож яваа тухай мэдээ хэвлэлээр олон удаа гарчээ. Өчигдөр гэхэд л Засгийн газрын ээлжит хуралдаанд эмч, багш, соёлын ажилтны хөдөлмөрийн хөлсийг нэмэх тухай асуудлаа оруулж, хэлэлцүүлж байх жишээний. Миний санах нь ээ, Залуучуудын, Ахмадын, Тэтгэврийн, Малчны тэтгэврийн насыг наашлуулах, Өндөр настны тэтгэврийн хэмжээг нэмэх тухай хуулийн төслүүд түүний нэрээр авторлогдон үлдэх болов уу. Өнгөрсөн намрын чуулганы хугацаанд 50 гаруй хоног Дорнод аймагт ажилласан бол он гарсаар 30 гаруй хоногийг тойрогтоо ажилласан хэмээн тайландаа дурьджээ. Энэ нь нэг талаасаа УИХ-ын гишүүний хувьд тойргоо хамгийн их "усалдаг", нөгөө талаас аймгийн МАН-ын хорооны гишүүний хувьд аймаг, орон нутагт хийж хэрэгжүүлж буй ажлуудтай нь салшгүй холбоотой биз ээ. Бүхэл бүтэн нэг аймгийг УИХ-д төлөөлнө гэдэг амаргүй. Гэвч тэр хэзээ ч хойш суудаггүй. Өөрийнхөө хэмжээнд тойргийнхоо асуудлыг шийдүүлж чадаж байгаа нь хувь улстөрчийнх нь хувьд овсгоо, дайчин чанар гэхээс өөрөө юу гэх вэ.

# ОРОН НУТАГ

*Аймгаас мэдээлж байна*

ДОРНОГОВЬ АЙМАГ

## Шинэчлэн батлагдсан хууль сурталчилах сургалтад 180 гаруй алба хаагч хамрагдлаа



Хууль зүй, дотоод хэргийн яамнаас УИХ-аар шинэчлэн батлагдсан Эрүүгийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн тухай сургалтыг аймгийн хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын 180 гаруй алба хаагч нарыг хамруулан, энэ сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

Сургалтын нээлтэд УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин оролцсон юм. Сургалтыг нээж, тус аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин "Аймгийн хэмжээнд 2017 оны эхний таван сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5 хувиар, захиргааны зөрчил өмнөх оны мөн үеэс 50.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ ч үүднээс энэхүү сургалтын үр дүнд хууль сахиулах чиг үүрэг бүхий төрийн алба хаагч та бүхэн шинээр дагаж мөрдөгдөж буй хуулиудыг нэг мөр ойлгож, иргэдэд таниулан сурталчлах, иргэдийн хуулиар олгогдсон эрх, ашгийг хамгаалж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэн ажиллана гэдэгт итгэж байна" гэв.

ДОРНОГОВЬ АЙМАГ

## Хүүхдийн чийрэгжүүлэлтийн зуны зуслан ажиллаж байна



Дархан-Уул аймгийн Засаг даргын санаачлагаар Эрүүл мэндийн газартай хамтран жил бүр урин дулаан цагт хүүхдийн сувилалыг нэг сарын хугацаатай ажиллуулдаг уламжлалтай ажээ. Тэгвэл 2017 оны зуны чийрэгжүүлэлтийн сувилал энэ сарын 12-ноос эхлэн ажилласан байна. уг зусланг‍ 18, 6 дугаар цэцэрлэгийг түшиглэн шинэ, хуучин дарханд явуулж байгаа гэнэ. Нэг ээлжиндээ 0-5 насны 20 хүүхдийг хамруулдаг бөгөөд сульдаа, рахит, цус багадалт зэрэг суурь өвчнийг нар, агаар, элс, шар сүү, сүүн бариа, бүх биеийн бариа, хэсэгчилсэн иллэг, массажаар эмчилж цагаан идээгээр үйлчилдэг байна.

Мөн эрүүл мэндийн газрын Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн Д.Цэцгээ, хүүхэд өсвөр үеийн кабинетын их эмч н.Мөнхзул болон сувилагч арга зүйч ажиллаж, хүүхдийг хүлээн авч анхны үзлэг, хэмжилт хийн жинг тодорхойлж, хүүхдийн хооллолт, асаргаа сувилгаа, наршилт, гэдэсний халдвараас хэрхэн урьдчилан сэргийлэх талаархи мэдээллийг эцэг эхчүүдэд хүргэжээ.

МЭРГЭЖИЛТЭН ЯРЬЖ БАЙНА

# М.ОТГОНЧИМЭГ: НЭГ Ч БАЙХ ЗАРЧМААР ЯВУУЛЫН

Н.БАТЗАЯА

*Дорноговь аймгийн ЗДТГ-ын Эрүүл мэнд, спорт, жендэрийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн М.Отгончимэгтэй ярилцлаа.*

**-Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газар хэчнээн хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэн ажиллаж байна вэ. 2016 онд ямар ажлыг гүйцэтгэв?**

-Манай аймгийн хэмжээнд нийт 84 эрүүл мэндийн байгууллага, 1000 гаруй эмч, эмнэлгийн ажилчин 66.6 мянга гаруй хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилладаг. Тодруулбал, хоёр нэгдсэн эмнэлэг, нэг сум дундын эмнэлэг, 12 сумын эрүүл мэндийн төв, 15 өрхийн эрүүл мэндийн төв, дөрвөн хувийн хэвшлийн эмнэлэг, 14 үүдэн эмнэлэг, зургаан эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага, хоёр халдваргүйтгэлийн газар, хоёр хувийн лабротори гурван сувилал гэсэн нийт 84 байгууллага орон нутгийнхаа иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй хүргэн ажиллаж байна. Хүний нөөцийн хувьд их эмч, эх баригч, сувилагч, багийн эмч, бусад мэргэжилтэн, ажилчид гэсэн нийт 1000 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Үүнээс их эмч 230 орчим, сувилагч 225, эх баригч 24, багийн эмч 34 бий. Өнгөрсөн жилтэй харьцуулахад, боловсон хүчний тоо тодорхой хэмжээгээр нэмэгдсэн хэдий ч зарим эмнэлэгт орон тоо хангалттай хэмжээнд биш. Түүнээс гадна хувийн хэвшилд 200 гаруй эмнэлгийн мэргэжилтэн ажилладаг. Гэхдээ эмч, эмнэлгийн мэргэжлтнүүдийн боловсон хүчин дутагдалтай. Бид 2016 онд өөрсдийн нөөц бололцоог ашиглан иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэн ажиллалаа. Ер нь хүн амын дунд амьсгалын замын тогтолцоо, бөөр, шээс бэлгийн замын болон ослоос үүдэлтэй гэмтэл, хордлого, гадны шалтгаантай үр дагавар, хоол боловсруулах эрхтний эмгэг, цусны эргэлтийн тогтолцоо зэрэг өвчлөл зонхилж байна. Мөн нас баралтын тэргүүлэх шалтгаанд цусны эргэлтийн тогтолцоо, зүрх судасны эмгэгүүд ордог. Энэ төрлийн өвчний улмаас иргэд амиа алдах тохиолдол их байгаа юм. Түүнчлэн амьсгалын замын өвчлөл, осол гэмтэл, хордлого, хоол боловсруулах эрхтний эмгэг нас баралтын шалтгаан болох боллоо. Аймгийн эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудал олон бий. Тэр дундаа сүүлийн үед зам тээврийн осол болон ямар нэгэн ослоос үүдэлтэй гэмтэл ихэссэн. Дорноговь аймагт бусад аймгийг бодвол дэд бүтэц, зам тээвэр харьцангуй хөгжсөн. Үүнээс үүсэлтэй зам тээврийн осол, зам тээврийн ослоор гэмтэл авсан иргэд нэмэгдэх болсон. Мөн яаралтай түргэн тусламжийн тасаг байгуулагдаж, стандартын дагуу ажиллаж байна. Гэвч хүн хүчний хувьд дутагдалтай талууд бий. Тухайлбал, иргэдэд хүрч үйлчлэх эмч, сувилагчийн тоо хүрэлцдэггүй байх жишээтэй. Ялангуяа сувилагч хүрэлцдэггүй. Яаралтай түргэн тусламжийн тасаг байгуулагдсанаар маш олон эерэг үр дүн гарч байгаа. Нас баралтын хувь буурсан, дуудлагын тоо багассан гэх мэтчилэн дурьдвал олон. Эндээс харахад, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж илүү сайжирсан. 2016 он Дорноговь аймгийн эрүүл мэндийн салбарынхны хувьд онцлох зүйл олон байлаа. Бидний ажлын үр дүн тодорхой хэмжээгээр гарсан гэж бодож байна. 2016 онд манай аймаг эрүүл мэндийн үзүүлэлтээрээ улсын хэмжээнд шилдгээр шалгарлаа. Мөн сүүлийн 2-3 жилд аймгийн хэмжээнд эхийн эндэгдэл гараагүй. Төрөлтийн хэмжээ харьцангуй нэмэгдлээ. Ер нь нэг үеэ бодвол аймгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан учраас нялхсын болон эхийн эндэгдэл буурсан үзүүлэлттэй байгаа.

**-Аймгийн төвд ихэнх бүтээн байгуулалт өрнөдөг. Тэр бүр суманд чиглэсэн бодлогын хэрэгжилт тийм ч сайн байдаггүй. Ер нь сумын эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвийн боловсон хүчин хэр хүрэлцээтэй байна вэ?**

-Сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн боловсон хүчний хүрэлцээ харилцан адилгүй л дээ. Зарим суманд эмчийн тоо хангалттай. Гэтэл эсрэгээрээ зарим сумдад эмч хүрэлцэхгүй байх жишээтэй. Тиймээс бид уг асуудлыг шийдэх зорилгоор боловсон хүчнээ бодлогоор бэлтгэж байна. Аймгийн Засаг дарга сумдуудтайгаа эрүүл мэндийн салбарын хүрээнд гэрээ байгууллаа. Гэрээнд эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бодлогоор бэлтгэх талаар заасан. Мэдээж бэлтгэж буй хүмүүсийнхээ сургалтын төлбөрөөс эхлээд ажиллах орчин, амьдрах орон байрыг сум, орон нутгаас гаргадаг байхаар гэрээндээ тусгасан. Энэхүү гэрээ хэрэгжиж эхэлснээр залуус хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллана. Түүнээс гадна аймгийн хэмжээнд өнгөрсөн онд 12 төрлийн 1742 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн. Амьсгалын замын халдвар, сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний тохиолдол 2016 онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Дорноговь аймаг хөдөлгөөнт хүн ам ихтэй. Зам тээвэр, дэд бүтэц хөгжсөн, хилийн боомттой учраас хүмүүсийн хөдөлгөөн тасралтгүй үргэлжилдэг. Үүнээс шалтгаалаад бэлгийн замын халдварт өвчний тохиолдол ихэсч байна л даа. Нэг талаас хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага ажиллаж буй нь нэгдсэн эмнэлэгт ирэх ачааллыг хуваалцаж байна. Бид эргээд хувийн эмнэлгүүддээ шаардлага тавих, тусгай зөвшөөрөл олгох зэрэгт анхаарал хандуулж, өндөр шалгуурыг тавьдаг. Хэчнээн хувийн эмнэлэг нэгдсэн эмнэлгийн ачааллыг хуваалцаж, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэдэг ч бид тусгай зөвшөөрөл олгох талаар маш нухацтай ханддаг. Яагаад гэвэл энэ салбар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэдэд шууд хүргэх учраас тэр. Үйлчилгээгээ илүү чанартай хүргэх талаар зөвлөж ажилладаг.

**-Хилийн зурвас дагуух аймаг учраас гадаад харилцаагаа өргөжүүлэхэд анхаарч ажилладаг болов уу гэж бодож байна. Гадаад харилцааны хүрээнд ямар ажил хийж байна вэ?**

-Дорноговь аймаг БНХАУ-ын Эрээн хоттой хил залган оршдог. Тиймээс ч бид урд хөрштэйгөө хамтын ажиллагаатай байхыг илүүд үздэг. Одоогоор ӨМӨЗО-ны Хөх хотын Олон улсын монгол эмнэлэгтэй хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны

...12 төрлийн 1742 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн. Амьсгалын замын халдвар, сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний тохиолдол 2016 онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Дорноговь аймаг хөдөлгөөнт хүн ам ихтэй. Зам тээвэр, дэд бүтэц хөгжсөн, хилийн боомттой учраас хүмүүсийн хөдөлгөөн тасралтгүй үргэлжилдэг. Үүнээс шалтгаалаад бэлгийн замын халдварт өвчний тохиолдол ихэсч байна л даа...


# ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “r-Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Налайх дүүргийн 2 дугаар хорооны 16 дугаар байрны 3 дугаар орцны тааз болон орцыг засварлах ажил”–ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналын баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 100’000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Төлбөрийг Төрийн сан банк 100200455009 тоот дансанд тушаана.

Үнийн саналыг 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 14.00 цаг-аас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 14.30 цаг-т нээнэ.

**Дотоодны давуу эрх: “Тооцохгүй”**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788**

# ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017.06.29
**Тендер шалгаруулалтын нэр:** Аймгийн хэмжээнд уст цэг шинээр тогтоох хайгуулын ажил
**Тендер шалгаруулалтын дугаар:** СБАОНӨГ/201706042

[Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгийн газраас] эрх бүхий тендерт оролцогчдоос [Аймгийн хэмжээнд уст цэг шинээр тогтоох хайгуулын ажил]–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д хандаж тендерийн бичиг баримтыг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй байх.

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх.

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил /2015, 2016 он/

**Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй.

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Тийм

- Усны хайгуул, судалгаа явуулах

Тендерийн хамт 2 000 000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг [2017 оны 07 дугаар сарын 31-ны 11 цаг 00 минут]–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг [2017 оны 07 дугаар сарын 31]-ны өдрийн, [11 цаг 30 минут]-д нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй**
**Дотоодын давуу эрх тооцно.**

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. (Ахлах мэргэжилтэн Ч.Батболд, Утас:96510404, 70518123)

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**[Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р баг Нутгийн удирдлагын ордон 3-н давхар, Орон нутгийн өмчийн газар, 306 тоот өрөө (Ахлах мэргэжилтэн Ч.Батболд, Утас:70518123, 96510404)]**

# ОРОН НУТАГ



# ИРГЭНИЙГ ОРХИГДУУЛАХГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЖ БАЙНА

хүрээнд уламжлалт анагаах, бариа заслын чиглэлээр эхний удаа 10 хүнийг сургалаа. Эдгээр эмч, мэргэжилтнүүд маань Олон улсын монгол эмнэлэгт долоо хоногийн турш ажиллангаа суралцсан. Хөх хотын эмнэлэг уламжлалт бариа засал, нөхөн сэргээх эмчилгээг яаж хийдгийг харж, өөрсдөө ажилласан. Практик давамгайлсан сургалт учраас илүү үр дүнтэй болсон. Эхнээсээ сум, өрхийн эмнэлэгтээ тэргүүн туршлага болгон хэрэгжүүлсэн үр дүн гараад байна. Энэ сургалтад зөвхөн улсын гэлтгүй хувийн хэвшлийн эмнэлгийн эмч нар ч хамрагдсанаара давуу талтай. Бид дараагийн ээлжийн сургалтад хамрагдах хүмүүсийнхээ нэрсийг гаргалаа. Хоёрдугаар ээлжийн багийнхан удахгүй сургалтдаа хамрагдана. Мөн эхний сургалтад хамрагдсан эмч нараас нэг санаачилга гарсан. Сургалтын хугацааг сунгаж өгөхийг хүссэн. Учир нь өөрийн биеэр суралцаж, эмнэлгийн үйл ажиллагаатай танилцахад долоо хоногийн хугацаа бага байна. Сурч мэдэх зүйлс олон байсан гэж бидэнд уламжилсан. Тиймээс бид энэ талаар Хөх хотын Олон улсын монгол эмнэлгийн удирдлагатай ярилцаж үзнэ. Мөн ӨМӨЗО-ны Бугат-Дархан муу мянган холбоот хошууны эмнэлэгтэй хамтран ажиллах санал тавьсан. Манай эрүүл мэндийн байгууллагын дарга өөрийн биеэр эмнэлгийнх нь үйл ажиллагаатай танилцаж, гэрээ хийх хүсэлт илгээсэн. Одоогоор хариу ирээгүй байна. Хэрвээ хамтран ажиллах гэрээ хийгдвэл эмч мэргэжилтнүүдээ шат дараатай сургалтад хамруулахаар төлөвлөөд байна. Түүнээс гадна ОХУ-ын эмнэлэгт хамтран ажиллах саналаа явууллаа. Гадаад харилцаан дахь хамтын ажиллагаанаас гадна төслийн хүрээнд хэд хэдэн ажил хийгдсэн. Тухайлбал, Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар аймгийн цусны төвийг иж бүрэн тохижуулдаа. Мөн эмнэлгийн хог хаягдал ариутгалын хэсгийг засварлаж байна. Одоогоор тоног, төхөөрөмж ирсэн. Удахгүй ашиглалтад орно. Ингэснээр эмнэлгийн хог хаягдлыг зориулалтын дагуу устгаж, халдваргүйжүүлэлтийн асуудал шийдэгдэх юм. Түүнчлэн ДЭМБ-тай хамтран Эрүүл мэндийн салбарын төрөөс баримтлах бодлогыг ИТХ-аар оруулж батлууллаа. Ер нь үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд дэд хөтөлбөр боловсруулж аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт эрүүл мэндийн чиглэлээр 43 заалтыг оруулсан. Энэ хүрээнд аймгийн эрүүл мэндийн дэд хөтөлбөрүүд ч боловсруулагдаж байна. Өнгөрсөн хугацаанд бид гурван хөтөлбөр батлуулсан. Нэгдүгээрт, "Элэг бүтэн Дорноговь" дэд хөтөлбөрийг баталсан. Мөн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт "Эрүүл шүд" аяны тухай тусгасан байдаг. Тиймээс энэхүү аяныг хэрэгжүүлнэ. Дэд хөтөлбөрүүд үйл ажиллагааны төлөвлөгөөтэйгөө гараад ирэхээр хаана ямар үйл ажиллагаа явуулах нь тодорхой болно. Дэмжээд ирэхээр нэлээд үйл ажиллагааны чиглэлүүд гарчихна.

**-Хилтэй залгаа аймаг учраас ямар нэгэн халдварт өвчлөл хүн амын дунд тархах магадлалтай юм байна шүү дээ?**

-Энэ талаар бид олон үйл ажиллагааг зохион байгуулж, арга хэмжээ авч ажилладаг. Би дээр хэлсэнчлэн манай аймаг дэд бүтэц хөгжсөн, хөдөлгөөнт хүн ам ихтэй. Өөрөөр хэлбэл, гадаад дотоодын иргэд дамжин урт болон богино хугацаагаар дамжин өнгөрдөг. Энэ их хөдөлгөөнийг дагаад зам тээврийн осол, амьсгалын болон замын өвчлөл их тохиолддог. Гэхдээ бид тухайн өвчлөлийг бууруулахад чиглэсэн бодлого боловсруулж, хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна. Удахгүй яамнаас орчны эрүүл мэндийн хөтөлбөр батлагдана. Яамны бодлоготойгоо уялдуулан дэд хөтөлбөрөө гаргадаг учраас одоогоор бид хүлээж байна.

**-Нийт 66 мянга гаруй хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүргэдэг гэлээ. Түүнээс гадна танай аймгаар дамжин өнгөрч буй иргэд эмнэлгийн тусламж авна. Ер нь тоног төхөөрөмж хэр хүрэлцээтэй байна вэ. Түргэн тусламжийн тасагт гэхэд машин хэрэгтэй шүү дээ. Мөн сүүлийн үед аймгуудад бүсийн оношлогооны төв, гемодиализын тасаг байгуулагдаж байна. Танай аймагт бий юу?**

-Аймгийн хэмжээнд хоёр нэгдсэн эмнэлэг бий. Нэг нь аймгийн төвд, нөгөөх нь Замын-Үүд суманд байдаг. Гемодиализын аппарат байдаг. Гэхдээ аппаратын тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Гемодиализын эмчилгээ авах шаардлагатай иргэдийн тоо ч нэмэгдэж байна. Үүнээс болж эмчилгээ авахыг хүссэн хүмүүстэй цаг алдалгүй тусламж үзүүлэхэд аппарат хүрэлцдэггүй.

**-Түргэн тусламжийн машины хувьд?**

-Сум болон өрхийн эмнэлгүүдийн автомашин хүрэлцдэггүй. Энэ талаар судалгаа хийхэд, одоо ашиглаж буй машины ихэнх нь насжилт хэтэрсэн, сэлбэг нь элэгдэж, муудсан байна билээ. Тиймээс Эрүүл мэндийн яаманд хүсэлт явуулсан. Ялангуяа нэгдсэн эмнэлгүүдэд хэвтрийн өвчтнийг тээвэрлэх зориулалтын эмнэлгийн автомашин хэрэгтэй. Одоогийн байдлаар фургон, 69 зэрэг автомашинаар л дуудлаганд явж байгаа. Үнэнийг хэлэхэд, яаралтай тусламж үзүүлэх болоход тэр машинууд чинь хэцүү шүү дээ. Хүчилтөрөгч өгөх шаардлагатай боллоо гэхэд тоног төхөөрөмж хангалтгүй байх жишээний. Магадгүй замдаа эрсдэл үүсэхийг үгүйсгэхгүй шүү дээ. Хөдөө сумын эмнэлгийн машин элэгдэл, хорогдолд орчихсон. Жишээлбэл, Мандал сум өөрийн гэсэн онцлогтой. Аймгийн төвөөс хол, зам нь хад асга ихтэй. Түүнээс болж машиных нь дугуй тэсдэггүй зэрэг асуудал гардаг. Гэхдээ аймгийн Засаг дарга 2017 он гарснаас хойш эхний ээлжинд аймгийн төв дэх дөрвөн өрхийн эмнэлгийн автомашины засварыг мөнгийг шийдвэрлэсэн. Нэг эмнэлэгт нь нэг сая 500 мянган төгрөг өглөө. Цаашид зарим эмнэлгийн тоног төхөөрөмжийг шийдэж өгөхөөр төлөвлөсөн.

**-Зарим хүмүүс улсын эмнэлэгт хэвтэснээс хувийн эмнэлэгт хэвтсэн нь дээр гэдэг. Энэ шалтгаанаа "Улсын эмнэлэгт үнэгүй хэвтдэг ч байсхийгээд л тийм эм авч ир, ийм дусал аваад ир гэдэг. Хувийн эмнэлэгт хэвтсэнтэй ялгаагүй зардал гарна" гэж тайлбарладаг. Хөдөө орон нутгийн эмнэлгийн эм хангамж, нийлүүлэлт, эмийн хүрэлцээ хэр байдаг вэ?**

-Нэгдсэн эмнэлгүүд тендэр зарлаж, эмийнхээ хангалтыг авдаг. Манай аймаг бас нэгэн онцлогтой. Тэр нь юу гэхээр, орон нутгийн өмчит эм эргэлтийн сан гэж бий. Энэ сан сумын эрүүл мэндийн төвийг эмээр хангах үүрэгтэй. Бусад аймагт орон нутгийн өмчит эм хангах нийлүүлэх сан байдаггүй. Уг сан маань бүрэн эрхийнхээ хүрээнд тендэр зарлаж, эмээ авдаг. Дараа нь сумынхаа эрүүл мэндийн төвүүдэд нийлүүлдэг. Ийм зарчмаар ажилладаг учраас эм тасрах тохиолдол бага. Яах вэ, зарим тохиолдолд хөдөө орон нутагт эм хангалтгүй байх тохиолдол гардаг. Захиалсан эм нь нэр төрлөөрөө байхгүй, татан авч чадаагүй гэх зэрэг асуудал үүсдэг. Бид эм эргэлтийн сангийн үйл ажиллагаагаа сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай уялдуулан гэрээ хэлэлцээр хийж ажиллахаар төлөвлөөд байна.

**-Гемодиализын аппарат ажиллаж байгаа гэлээ. Энэ аппарат өөрөө урсгал зардал өндөртэй байдаг. Маш үнэтэй шингэн ашигладаг. Түүнийг хэрхэн зохицуулж байна вэ?**

-Асуудал бий. Урсгал зардлыг нэгдсэн эмнэлэг өөрсдөө зохицуулдаг. Гемодиализын аппаратнаас гадна дурангийн хоёр том аппарат маань эвдэрсэн. Яам руу хүсэлт явуулж нэгнийх нь асуудлыг шийдвэрлүүллээ. Эндээ засах боломж байхгүй. Засварын төлбөр өндөр үнэтэй.

**-Завсартай холбогдуулж нэг зүйлийг асууя. Эмнэлгийн байгууллагын нэг амин сүнс нь техникийн ажилчид. Тухайн эмнэлгийн тоног төхөөрөмж хэвийн ажиллах нь техникийн ажилчдаас хамааралтай байдаг. Энэ хүмүүсийг бэлтгэх талаар ямар ажил хийж байна. Одоо ажиллаж байгаа хүмүүс нь мэргэжлийнх үү?**

-Одоогийн ажиллаж буй хүн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер гэдэг мэргэжлээр төгсөөгүй. Гэхдээ техникийн мэргэжилтэй хүн. Манай улсад ШУТИС энэ төрлийн мэргэжилтнийг бэлтгэж байгаа ч орон нутагт ирж ажиллах залуус ховор байна. Тиймээс энэ төрлийн мэргэжилтнүүдийг бэлтгэх зайлшгүй шаардлагатай. Бид хүний нөөцийн төлөвлөгөөндөө бодлогоор оруулсан. Ихэнхдээ хуучин ажиллаж байсан техникч нар маань ажиллаж байна. Зарим том тоног төхөөрөмжийг засварлахаар бол улсын эмнэлгүүдээс зөвлөгөө авдаг. Хэрвээ тоног төхөөрөмжөө өгч явуулах шаардлагатай бол өгч явуулаад засдаг. Эрүүл мэндийн салбарын хүний нөөц сайн байж тодорхой хэмжээгээр үр дүн нь гарна гэж боддог. Одоогоор салбарын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулаад байна. Өөрөөр хэлбэл, бодлогын баримт бичгийн хүрээнд аймагт ямар мэргэжлийн хүн дутагдалтай байгааг тооцож гаргасан гэсэн үг. Мөн сүүлийн үед эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд ёс зүйн алдаа гаргаж байна. Үүнтэй холбоотой санал гомдол ч ирсэн. Дорноговь аймгийн эрүүл мэндийн салбарын хувьд ёсзүй, харилцаа хандлагатаа анхаарч ойрхон зайтай олон сургалтыг зохион байгуулж байна.

**-Нарийн мэргэжлийн эмч нар хөдөө орон нутагт дутагдалтай байдаг шүү дээ. Танай аймгийн хувьд ямар мэргэжлийн эмч илүү шаардлагатай байна вэ?**

-Аль ч аймагт адилхан байгаа болов уу. Манай аймагт эрэгтэйчүүдийн эмч дутагдалтай байдаг. Энэ хүрээнд нэг хүнийг бэлтгэж байгаа. Ер нь жендэрийн асуудалтай холбоотойгоор үргэлж эмэгтэйчүүдэд анхаардаг. Наад зах нь гэхэд эмэгтэйчүүдийн эмнэлэг олон байдаг шүү дээ. Харин эрэгтэйчүүдийн эмнэлэг цөөхөн. Тиймээс нийт өвчлөлийн ихэнх хувийг эрчүүд эзэлдэг. Ялангуяа хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, элэг цөсний эмгэгийн өвчлөл их бий. Тиймээс эрэгтэйчүүдийн эмчийг бэлтгэх зайлшгүй шаардлагатай юм байна гэдэг үүднээс нэг хүнийг сургаж байна. Мөн дүрс оношлогоо, компьютер тоног төрөөмж дээр ажиллах эмч бид бэлдэх хэрэгтэй. Нярайн эмч, эх барих эмч ч дутагдалтай болоод байна. Хоёр эмч маань шилжчихсэн. Нэмээд хэлэхэд, аймгийн Засаг даргын зүгээс цаг үетэй холбоотой өвчлөлүүдэд их дэмжлэг үзүүлдэг. Эрүүл мэндийн тулгамдсан асуудал, өвчлөлийн дэгдэлт гарах, вакцинжуулалт хийхэд маш нааштайгаар шийдэж өгдөг. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн салбараа маш дэмжиж ажилладаг. Манай аймгийн хувьд алслагдсан сум, багуудад хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим баримталдаг. Энэ улсын хэмжээнд эрүүл мэндийн салбарын гол уриа болсон. Энэ хүрээнд малчдад эмнэлгийн тусламж үйлчилгээх хүргэх үүднээс явуулын үзлэгийг эрчимжүүлсэн. Оторт байгаа малчин, хөдөө байгаа хүүхдийг ч орхигдуулахгүй байх үүднээс явуулын үзлэгийг хийж байна.

**-Хөдөө орон нутгийн ихэнх эмнэлгийн барилга хуучирсан байдаг. Танай аймагт эмнэлгийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажил өрнөж байна уу?**

-Удаан хүлээлгэсэн төрөх эмнэлгийн асуудал шийдэгдэх шатандаа орсон. Мөн Замын-Үүд суманд 100 ортой эмнэлгийн барилгын асуудал шийдэгдэх шатандаа ороод байна. Түүнчлэн аймгийн төвд VI багт иргэдийн хөгжлийн төвийг байгуулна. Тэр төв дотроо нэг өрхийн эмнэлэгтэй байх юм. Бүтээн байгуулалтын ажил нь эхэлчихсэн.

## Аймгаас мэдээлж байна

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

### Говьсүмбэр аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт машин өгчээ

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга М.Мөнхбаясгалан Говьсүмбэр аймагт энэ сарын 21-нд ажиллажээ. Тэрбээр аймгуудын Хүнс хөдөө аж ахуй газар, сумын мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтнүүдтэй уулзалт хийж Монгол Улсын Засгийн газар, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрийн талаар мэдээлэл хийсэн байна. Тодруулбал, төрөөс Хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, "Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн" зорилтын хүрээнд "Мах сүүний анхдугаар аян", "Атрын III аян"-ыг эрчимжүүлэн үргэлжлүүлэх, "Үйлдвэржилт 21:100", "Ноолуур", "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн талаар мэдээлэл хийж, орон нутагт хэрэгжүүлж байгаа бодлогын талаар чиглэл, зөвлөмж өгч ажиллажээ. Мөн хүнс хөдөө аж ахуйн салбарын ажил, үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор тус аймгийн хөдөө аж ахуйн газарт фургон, сумын мал эмнэлэг үржлийн тасагт мотоцикл хүлээлгэн өгсөн байна. тус аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар сүүлийн жилүүдэд унаа тэрэгний шинэчлэл хийгдээгүй, хүрэлцээгүй байсныг ийнхүү шийдвэрлэжээ.

СЭЛЭНГЭ АЙМАГ

### Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум лед гэрэлтэй болно

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын хэмжээнд гудамж талбайн 1100 гаруй гэрэлтүүлэг байдаг аж. Эдгээр гэрэлтүүлэг нь 250 вольтоор ажилладаг учраас цахилгааны төлбөр ихээхэн гарахад нөлөөлдөг аж. Тиймээс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэрээр аймгийн "Сэлэнгэ үйлчилгээ" ОНӨААТҮГ-т 30 сая төгрөгийг шийдэж өгчээ. Энэхүү хөрөнгөөр тус байгууллага гудамж талбайн гэрэлтүүлгээ 150 Вт-аар ажилладаг, цахилгаан эрчим хүчийг 50 хувь бууруулах лед гэрлээр солих ажлыг эхэлжээ. Уг гэрэл нь цахилгаан эрчим хүчинд хэмжнэлттэйгээс гадна хотын өнгө үзэмжинд ч нөлөө үзүүлэх гэнэ. Эхний ээлжинд Сүхбаатар сумын хорооллын V багаас гурвалжин хүртэл 68 шон, гурвалжингаас "Хулан хатан"-ны хөшөө хүртэл 68 шонгийн гэрэлтүүлгийг сольсон байна. Өмнө нь тус байгууллага зуны улиралд цахилгааны төлбөрт таван сая төгрөг төлдөг байжээ. Харин энэхүү лед гэрлийг тавьснаар 50 хувь хөнгөлж хоёр сая 500 мянган төгрөг хэмнэх боломжтой болж бүрдэх юм байна. Гэрэлтүүлгийг шинэчлэх ажил цаашид үе шаттайгаар хийгдэнэ. "Сэлэнгэ үйлчилгээ" ОНӨААТҮГ нь Сүхбаатар сум дахь Олон улсын худалдааны төв, Гэрэлт цогцолбор, Сүхбаатар хот доторх нийтийн тээвэр, мах боловсруулах зоорь, гэрэлтүүлгүүд, Сайханы хөтөл зэргийг хариуцан ажилладаг байна. Цаашид хотын өнгө үзэмжийг сайжруулах үүднээс үргэлжлүүлэн үлдсэн гэрлүүдийг лед гэрлээр солих ажил хийгдэх ажээ.

MNB
MONGOLIAN NATIONAL BROADCASTER

## НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО НАЙРУУЛАГЧ СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

**НАЙРУУЛАГЧ /2/**
**Ажлын байрны зорилго:**

Сонсогчдын оюуны таашаалд нийцсэн, тэдний итгэл үнэмшлийг хүлээсэн радио сэтгүүл зүйг мэргэжлийн өндөр түвшинд найруулан ажиллана.

**Ажлын байранд тавигдах шаардлага:**

- Радио телевизийн найруулагч болон оператор мэргэжлээр төгссөн, дууны болон дүрсний найруулга хийх чадвартай байх /бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй/
- Найруулагчийн ажлын туршлагатай эсвэл мэргэжлийн бүтээлтэй байх, радиогийн ажлын болон нэвтрүүлгийн онцлогийг сайтар мэддэг
- Эфирийн техник, тоног төхөөрөмж дээр бүрэн ажиллах чадвартай байх
- Уран бүтээлч сэтгэлгээтэй
- Багаар ажиллаж, ачаалал даах чадвартай, харилцааны соёлтой
- Ажлын болон хувийн зохион байгуулалт сайтай, хариуцлага хүлээх чадвартай
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй

**Бүрдүүлэх материал:**

- Өөрийн хийсэн 3 бүтээлийг "DVD"-нд хуулбарлаж өгөх
- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын "Бусад" гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
- Их, дээд сургууль төгссөн диплом болон бусад материалыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн битүүмжилсэн дугтуйд хийж 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

**Хаяг: Баянгол дүүрэг, Хувьсгалчдын зам-3**
**Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз**
**Хүний нөөцийн алба, Утас: 325802**

# ЗАВСАРЛАГА

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ



## Батон Руж ДАХЬ ЭСЭРГҮҮЦЭЛ

Б.СУМЪЯА

Зураг дээрх өнгөт арьст бүсгүйг Иэша Эванс гэдэг. Тэрбээр АНУ-ын Луйзанна мужийн Батон Руж хотын цагдаагийн газрын гадна хуулийн байгууллагынхны өнгөт арьснуудын эсрэг хүчирхийллийг эсэргүүцсэн жагсаалын үеэр зэвсэглэсэн салаа цагдаагийнхны өмнөөс гартаа ганц ч зэвсэггүй сөрөн зогсож буй нь энэ. Өмссөн цоохор даашинзнаасаа өөр зэвсэггүй сул дорой бүсгүй 2016 оны долдугаар сарын 5-нд хоёр цагаан арьст цагдаагийн алба хаагчид буудуулан амиа алдсан Алтон Стерлингийн үхэлтэй холбогдуулан Батон Руж хотод эсэргүүцлийн жагсаалд оролцохоор ирсэн байна. Алтон Стерлинг цагдаагийнхны хүчирхийлэлд өртөн амиа алдсан өнгөт арьстнуудын нэг байсан юм. Албаны тоон мэдээллээс үзвэл, 2016 онд 15-34 насны нийтдээ есөн өнгөт арьстан амиа алдсан байна. Сувилагч мэргэжилтэй, таван настай хүүтэй Эванс бүсгүй энэхүү эсэргүүцлийн хөдөлгөөний үеэр баривчлагдсан гэдэг. Гэхдээ төд удалгүй суллагдсан юм. Ямартай ч, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл өнөө хэр АНУ-д оршсоор буйг эсэргүүцсэн жирийн нэгэн бүсгүйн зураг дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “World press photo-2017” наадмын “цаг үеийн асуудал” төрөлд тэргүүн байр эзэлжээ. Зургийг “Ройтерс” агентлагийн зурагчин Жонатан Бэкмэн 2016 оны долдугаар сарын 9-нд гэрэл зургийн хальснаа буулгасан байна. Тэрбээр тухайн үеийн нөхцөл байдлын талаар ярихдаа “Би зам дээр цагдаа нарын эсрэг эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлж буй жагсагчдын зургийг аваад явж байлаа. Тэгэж явахдаа нэг бүсгүй зам дээр зогсч байхыг харсан. Тэр бүсгүй цагдаа нарын өмнө зогсоод, юу ч хэлээгүй, бас ямар нэг хөдөлгөөн хийгээгүй. Цагдаа нар түүнийг баривчлах нь ч тодорхой байсан” гэж ярьжээ.

Улаанбаатарт:



Маргааш

Өдөр 33
Шөнө 17



Нөгөөдөр

Өдөр 34
Шөнө 17

Өдрийн зурхай

**ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САР ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ГАХАЙ ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 04.56-20.55

**Үс засуулбал:** Өнгө зүс сайжирна



*Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээх, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олдоно. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой.*

## НЯМБУУГИЙН БОЛОРМАА
## (1973-2017)



"Чөлөөт хэвлэл сан" хэвлэх үйлдвэрийн Гүйцэтгэх захирал Нямбуугийн Болормаа 2017 оны 6-р сарын 26-ны өдөр хүнд өвчний улмаас таалал төгсч, гэр бүл, төрөл төрөгсөд, хамт олонд нөхөж баршгүй гарз учирлаа.

Н.Болормаа 1973 оны 04-р сарын 11-ний өдөр Дундговь аймгийн Хулд суманд төржээ. 1989 онд Дундговь аймгийн Хулд сумын найман жилийн дунд сургууль, 1991 онд Дундговь аймгийн арван жилийн 1 дүгээр дунд сургууль, 1996 онд МУИС-ийн НУФ-ийг сэтгүүлч мэргэжлээр суралцан төгсөж, 1998 онд МУИС-д Нийгмийн ухааны магистрийн зэргийг амжилттай хамгаалсан байна.

Тэрээр 1998 оны 1-р сарын 20-ны өдрөөс эхлэн тухайн үеийн "ДАНИДА" одоогийн "Чөлөөт хэвлэл сан" хэвлэх үйлдвэрт Нарийн бичгийн даргын үүрэгт ажлаар ажил хөдөлмөрийнхөө гарааг эхлүүлж, 2011 оноос эхлэн Гүйцэтгэх захирал хэмээх хариуцлагатай албан тушаалд дэвшиж, хийж бүтээх бүхий л үйл хэрэгтээ өөрийн авьяас чадвар, билэг оюун, эрхэм нандин зан чанараа дайчлан ажилласаар ирсэн. Түүний бүхий л ухамсарт амьдрал, хөдөлмөр нь "Чөлөөт хэвлэл сан" хэвлэх үйлдвэр, Монгол дахь хэвлэлийн эрх чөлөө, чөлөөт сонин хэвлэлийн хөгжилтэй нягт холбоотой билээ.

Монгол улсын эдийн засаг хийгээд байгууллагын зах зээл дэх нөхцөл байдал хүндэрсэн үед бизнесийн удирдлага, менежментийн оновчтой шийдэл гаргаж, 2013 онд зоригтойгоор үйлдвэрлэлийн өргөтгөл шинэчлэлийг хийснээр үйлдвэрлэлийн 2-р шугам эрчимжиж, Чөлөөт хэвлэл сангийн үйл ажиллагаа тогтворжсон нь Монгол дахь ардчилсан чөлөөт хэвлэл, чөлөөт сонинуудын хэвлэлт болон эрдмийн их өргөл болсон ном хэвлэлтэнд нэгэн шинэ алхам хийсэн юм.

Түүний ухаалаг мэргэн шийдвэрийн дор нэгэн зорилгод нэгдсэн хамт олон нь Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн дунд шилдэг байгууллага нь болж, 2011 онд Монголын маркетинг менежментийн хүрээлэнгээс зохион байгуулсан "Гранд экспо 2012" үндэсний бизнес фестивальд Хүнд, хөнгөн үйлдвэрийн салбарын ТОП-5 хэвлэх үйлдвэрийн нэгээр шалгарсан юм.

Түүний хөдөлмөр, хийж бүтээсэн үйл хэргийг нь Монголын хэвлэл мэдээллийн салбар болон Монгол улсын засгийн газар өндрөөр үнэлж, 2006 онд Монголын хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан цол тэмдэг, 2011 онд Нийслэлийн тэргүүний залуу алтан медаль, 2012 онд Бизнесс эрхлэгч эмэгтэйчүүдийн холбооны хүндэт тэмдэг, 2013 онд Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбооны 100-н жилийн ойн хүндэт медаль, 2014 онд Хүнс хөдөө аж ахуйн яам хөнгөн үйлдвэрийн салбарын 80-н жилийн ойн хүндэт медаль, 2016 онд Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дээд зөвлөлийн хүндэт медаль, Монгол улсын засгийн газрын шагнал "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар тус тус шагнагджээ.

Хувь хүний эрхэм чанар болсон хатан ухаан, зөөлөн сэтгэл, мэдрэмжийг ажил хэргийн нарийн мэдлэг, чадвар, мөн уйгагүй, хөдөлмөрч эрхэм чанаруудыг хослуулсан тэрээр хамт олныхоо төлөө зүрх сэтгэлээ зориулж ирсэн бүх л үйл хэргээс нь харагддаг байлаа.

Түүний Монгол улсын хэвлэлийн салбарын болон үйлдвэр, хамт олныхоо хөгжлийн төлөө зориулсан чин сэтгэл, хөдөлмөр зүтгэл, амжилт, үйлс бүхэн нь түүнийг хайрлан хүндэтгэдэг хүн бүхний сэтгэлд үүрд орших болно.

Талийгаачийн гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд, ажлын хамт олонд гүн эмгэнэл илэрхийлье.

**Ум сайн амгалан болтугай.**

**“Чөлөөт хэвлэл сан” хэвлэх үйлдвэр**
**Монголын Хэвлэх Үйлдвэрүүдийн холбоо**

ДУУЛГАХ СОНИН

## Хакүхо зүүнийг тэргүүлнэ



Мэргэжлийн сумо бөхийн Нагоя башё ирэх сарын 9-23-нд болох тов гарлаа. Зуны башёг өнгөрсөн сард 38 дахь түрүүгээ авсан ёкозуна Хакүхо М.Даваажаргал тэргүүлэх юм. Харин баруун жигүүрийг Харүмафүжи Д.Бямбадорж тэргүүлнэ. Харин зүүний дагаварт Кисенасато, барууны дэд магнайгаас Какирюу М.Ананд босно.

Дээд зиндаанд Монголын есөн бөх барилдах бөгөөд Тэрүнофүжи Г.Ган-Эрдэнэ арслан цолтнуудаа тэргүүлэн барилдахаар болов. Энэ башёд Тамаваши Б.Мөнх-Оргил сэкиваке цолтойгоор дөрөв дэх удаагаа барилдах юм. Тэгвэл маэгашира цолтнуудаас Чиёошима Г.Мөнхсайхан зүүний тавд, Ичиножёо А.Ичинноров зургаа, Такайнова А.Баасандорж долоод, Араваши Э.Дөлгөөн 12-д бичигдлээ.

*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

## Капсийскийн дэвжээ чөлөөтийнхний эхний шалгалт болно

Чөлөөт бөхийн дэлхийн таван удаагийн аварга Дагестаны алдарт бөх Али Алиевын нэрэмжит эрэгтэй бөхчүүдийн уламжлалт олон улсын тэмцээн ирэх сарын 9-10-нд Капсийск хотод болно. Манайхаас энэ тэмцээний 57 кг-ын жинд З.Занабазар, 61 кг-д Т.Түвшинтулга, 65 кг-д Н.Лхамгармаа, 70 кг-д гавьяат тамирчин Г.Мандахнаран, 74 кг-д Д.Гомбодорж, 86 кг-д О.Уйтүмэн, 97 кг-д Ч.Алтангэрэл нар Үндэсний шигшээ багийн туслах дасгалжуулагч Б.Батзоригийн удирдлага дор оролцох юм. Энэ тэмцээнд Парист болох ДАШТ-д зодоглох манай найман эрэгтэй тамирчдын тав нь багтжээ. Өөрөөр хэлбэл эрчүүд маань ДАШТ-ий өмнөх бэлтгэл хэрхэн байгааг шалгах юм. Үүний араас Болгарт олон улсын тэмцээн болох бөгөөд энэ хоёр тэмцээнээс бөхчүүдийн бэлтгэлжилт хэр төвшинд байгааг шинжих боломжтой. Сонирхуулахад, Али Алиевын нэрэмжит тэмцээнд гавьяат тамирчин Б.Наранбаатар долоон жилийн өмнө мөнгө, арван жилийн өмнө хүрэл медаль хүртэж байв.

СОНИРХУУЛАХАД

## “МӨНХИЙН ЗАЛУУ” гэр бүл цахим ертөнцийг шуугиулж байна



Нас гэдэг ердөө тоо гэдгийг Тайванийн нэгэн гэр бүлийн эмэгтэйчүүд харуулж байна. Тэдний гэр бүлийн зургийг харсан хэнбугай ч ээж нь хэдийнэ 63 насны босго алхсан, охид нь 41, 40, 36 настай гэдэгт итгэхгүй. Охидынх нь хамгийн томыг нь Люре Хсу гэдэг. Тэрбээр интерьер дизайнер бөгөөд загварын блог хөтлөдөг байна. Түүний дүү Фэйфэй Хсу 40 насны төрсөн өдрөө саяхан тэмдэглэсэн бөгөөд хоёр хүүхэдтэй бол бага охин Шарон нь 36 настай, Тайвандаа загвар өмсөгчөөр ажилладаг аж. Эгч дүү гурвын насыг харвал дунд эргэм насныханд тооцогдохоор. Гэвч, наснаасаа хоёр дахин залуу буюу өсвөр насны охид шиг л харагддаг аж. Харин ээжийг ихэвчлэн хүмүүс 30-тай гэж хардаг ч, үнэн хэрэгтээ 63-тай гэнэ.

Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд



Sukhbayar Sidka

Манай нэг танилын аав нь нэг шөнө нэлээд унгаж хоножээ. Тэгсэн маргааш нь ээж нь “шөнөжин өмхий юман дундуур алхаж байна гэж зүүдэллээ” гэсэн гэнэ. Та нарын ч гэсэн ойр тойронд өмхий унгагч байгаа биз дээ.